13	MN-MMRA - 300000585	Амьсгаадаж, дотор давчдаж, биеэр загатнаж, биеийн бүх хэсгээр улаан тууралт гарсан.	Сүрьеэ өвчний улмаас HRZE хослолоос харшсан тул, Н-300мг эмийг сольсон	Изониазид	Изониазид	Ө/Ү	Хүнд (Түвшин 4)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
14	MN-MMRA - 300000586	Амьсгаадаж, дотор бачуурч, биеэр харшлын тууралт гарч, загатнасан ()	Сүрьеэгийн эмчилгээнд	Рифамицин	Рифамицин	Stop TB Partnership GLOBAL DRUG FACILITY	Хүнд (Түвшин 4)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
15	MN-MMRA - 300020628	Гар хүчтэй өвдөж, дотор муухайрч, давчидсан	Бие махбод хүчилших	Натрийн гидрокарбонат 4%-100 мл	Натрийн гидрокарбонат 4%-100 мл	Тавин Ус эмийн үйлдвэр	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
16	MN-MMRA - 300000589	загатнасан, улаан тууралт гарч, хавдсан	Тодосгогчтой КТГ- ын шинжилгээнд орх зорилгоор	Йопромид	Ультравист	Bayar AG Герман улс	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
17	MN-MMRA - 300000590	загатнасан, тууралт гарсан	тодосгогчтой КТГ- ын шинжилгээнд орх	Йопромид	Ультравист	Bayar AG Герман улс	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
18	MN-MMRA - 300000591	Дотор муухай оргиж , бие сулласан, нүд харанхуйлсан	Үрэвсэл дарах	Цефатоксим	Цефатоксим	NCPC	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)

19	MN-MMRA - 300000592	Цээж,хэвлий,дээд мөчдөөр бэлцрүүт улаан тууралт арсан загатнана.	Мэс заслын өмнөх бэлтгэл	Цефотаксим	Цефотаксим	Красфарм	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
20	MN-MMRA - 300000593	Бүх бие халуу оргиж улайсан загатнасан	ПНЕВМОНАЯ	Ванкомицин	Ванкомицин	КРАСФАРМА	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
21	MN-MMRA - 300000594	Нүүр халуу оргиж, бадайрч, хацар, эрүү хэсгээр ирвэгнэсэн.	Хий арвидсаныг эмчлэх зорилгоор хэрэглэсэн.	Агар-8	Агар-8	Одь тан ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
22	MN-MMRA - 300000598	Судас дагаад улаан болсон мөн нөгөө гараар улаан тууралт гарсан	Үений үрэвсэл	Офлаксацин	Офлаксацин	Энхийн шүүдэр	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
23	MN-MMRA - 300000600	Бие салганасан чичрэнэ, Хөлөрнө, Артерийн даралт 150/100, судасны цохилт 1 минутанд 151 удаа	F20.8	Галоперидол 5мг	Галоперидол 5мг	Whan in pharm, БНСУ	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
24	MN-MMRA - 300000601	Гар хөл салганаж, дотор давчдах, нүүр таталдах.	F20.8	Галоеридол 5 мг	Галоперидол 5мг	Whan in pharm, БНСУ	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
25	MN-MMRA - 300000602	Нүд дээш солийж харах, шүлс гоожих, хүзүү биеэрээ мушгирч, гар татсан	F71.1 Оюуны хүндэвтэр хомсдол	Флуфеназин	Модитен депо	КРКА	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
26	MN-MMRA - 300000603	Дотор муухайрч, хүйтэн хөлс гарч, чичрүүдэс хүрнэ, толгой эргэнэ.	Тархины цусан хангамж сайжруулах	Инозин + Никотинамид + Рибофлавин + Сукцины уламжлал	Цитофлавин	ОХУ, Scientific Technological Pharmaceutical Firm ” POLYSAN ”, LTD	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
27	MN-MMRA - 300000604	Нүүр халуун оргих, чинэрэх, хатуурах мэдрэмж. Цээж хэсгээр улаан тууралт гарсан. Толгой эргэх, дүүрэх мэдрэмж төрсөн.	Cutaneous abscess	Trimethoprim and sulfamethoxazole (Bidiseptol)	Бидисептол	Binh Dinh pharmaceutical and medical equipment Вьетнам	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
28	MN-MMRA - 300000605	Дотор муухайрах, гүйлгэх, арьсаар загатнах,	Өндгөвчний үрэвсэл	Клиндамицин	Клицин	Hankook korus. pharm co.,ltd	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)

29	MN-MMRA - 3000000606	Дотор муухайрсан	Толгой өвдөх	Пирацетам	Пирацетам	Орос	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
30	MN-MMRA - 3000000607	Улайж хавдсан Даралт ихэссэн	Дархлаа сэргээх	Астрио	Астрио	PT. Pertiwi Aging	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
31	MN-MMRA - 3000000608	Биеийн арьсны нимгэн хэсэгт улаан тууралт гарч, загатнасан.	Бөөрний үрэвсэл	Жонлон 5	Жонлон 5	Мон-Инх	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
32	MN-MMRA - 3000000609	Агар35	ГММ16	Агар35	Агар36	Моннигра байгаль	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
33	MN-MMRA - 3000000610	Толгой маш хүчтэй өвдсөн	Ашигтай бактер дэмжих	Лактофлор биоплюс	LactoFlor BioPlus	Kendy Болгар	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
34	MN-MMRA - 3000000611	Дотор муухайрсан, бөөлжис цутгасан, бүх бие бадайрсан	Бөөр, шээсний замын үрэвсэл, Байнгын шээлгүүртэй	Цефазолин	Цефазолин	Нахиа Импекс ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
35	20240001	Биеийн жин буурсан	II хэлбэрийн чихрийн шижин	Дапагглифлозин	Форсига	Астразенека	Хүнд (Түвшин 4)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
36	MN-MMRA - 3000000583	Судас дагаж янгинасан. Цээж хөндүүрлэж, хийлсэн мэт дүүрсэн, ар дагз чинэрч янгинаж толгой өвдсөн, дотор муухайрсан	Элэг тархины хам шинж	Л-орнитин-Л- аспартат Нерагард	Хепагард	United Biotech (P) LTD	Ноцтой (Түвшин 5)	Б хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
37	MN-MMRA - 3000000612	Дотор муухайрч, аюулхайд халуу оргих	Liver cirrhosis, HBV and HDV child рugh C	Л-орнитин-Л- аспартат	Хепагард	United biotech БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
38	MN-MMRA - 3000000615	Хөхөрсөн, бөөлжсөн, хөлөрсөн, нүд сөлийсөн.	Уушгины хүнд хатгалгаа / Дахилтат/	Метронидазол	Метронидазол	Айвико ХХК	Хүнд (Түвшин 4)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)

39	MN-MMRA - 300000616	Хэл бадарч, бие зарайж, толгойн хуйх, ар нуруу орчмоор зарайж /шар үс босох мэт/ эхэлсэн. Дээрх шинж тэмдэг 1-2 цаг үргэлжилсний дараа бие эргээд хэвийн байдалд орсон.	Доод мөчдийн цагаан судлын өвчинд	Гарьд 13	Гарьд 14	Одь тан ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
40	MN-MMRA - 300000617	Дотор муухайрах ,огиулна, цээж давчдана	Онош тодруулах	Йогексол	Омнипак 300	GE healthcare	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
41	MN-MMRA - 300020618	Биеэр битүү улаан тууралтууд гарсан	Уушгины хатгалгаа	Ампициллин	Ампициллин 1гр	NCPC	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
42	MN-MMRA - 300020619	Биеэр битүү улаан тууралтууд гарсан	Уушгины хатгалгаа	Ампициллин	Ампициллин 1гр	NCPC	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
43	MN-MMRA - 300020620	хамаг бие загатнасан, бага зэрэг толгой өвдсөн	Үндсэн оношын дагуу	Сүгмэл 3	Сүгмэл 3	Мон-Интра	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
44	MN-MMRA - 300020621	Хөлс цутгаж, амьсгал давчидсан, хэвлийн хэсгээр баазалж өвдсөн.	Хүзүүний өвдөлт	Гадовист	Гадовист	Bayer AG Герман улс	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
45	MN-MMRA - 300020622	Биеэр гүвдрүүт тууралт гарсан загатнана	Сүрьеэгийн эмчилгээнд	HRZE	HRZE	Macleods Pharmaceutical БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
46	MN-MMRA - 300020623	Тууралт гарч, загтнаж, цэрүүтсэн	Тулай	Аллопуринол	Аллопуринол	Ө/Ү	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
47	MN-MMRA - 300020624	Гэнэт дотор муухайрч, хүйтэн хөлс гарч унах шахсан. гэнэт дотор муухайрч, хүйтэн хөлс гарсан.	z51.1 Хавдрын хими эмчилгээ	Паклитаксел	Пакливел	Getwell Pharmaceutical	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
48	MN-MMRA - 300020625	толгой эргэх амьсгал тавчдах зүрх дэлссэн	Бүдүүн гэдэсний хорт хавдар	Фторурацил (Fluorouracil)	5-Фторурацил Эбеве	Ө/Ү	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)

49	MN-MMRA - 300020626	Бөгшүүлж ханиалгаж эхэлсэн. Амьсгалахад хүндрэлтэй болсон.	Malignant neoplasm of upper lobe, bronchus or lung - Цээжний бага зэргийн өвдөлт	Каффетин	Каффетин	Alkaloid AD Skorje	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
50	MN-MMRA - 300020627	Зүрх савлаж, толгой эргэж, дотор муухайрсан	Бактерт пневмони	Аминофиллин	Эуфиллин	Dalchempharm OJSC, OХУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
51	MN-MMRA - 300000613	Дотор муухайрч огиудас хүрэх	Хепатит	Л-орнитин-Л- аспартат Нерагад	Хепатард	United biotech БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
52	MN-MMRA - 300020629	Бүх бие улайж загатнаж хэвлий хэсгээр бэлцрүүт тууралт гарсан	E.Coli-мэдрэг	Хлорамфеникол	Хлорамфеникол	Тун эрдэнэ үйлдвэр	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
53	MN-MMRA - 300020630	Улаан тууралт гарсан	Цочмог бронхит	Цефотаксим	Цефотаксим	Нахиа Импекс ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
54	MN-MMRA - 300020631	2 Нүд час улайж загатнасан.	Сүрьеэгийн эмчилгээнд	HRZE	HRZE	Macleods Pharmaceutical БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
55	MN-MMRA - 300020632	Биеийн бүх хэсгээр харшлын тууралт гарч загатнана, амьсгаадна.	Сүрьеэгийн эмчилгээнд	HRZE	HRZE	Macleods Pharmaceutical БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
56	MN-MMRA - 300020633	Биеийн бүх хэсгээр харшлын тууралт гарч загатнана, амьсгаадна.	Сүрьеэгийн эмчилгээнд	HRZE	HRZE	Macleods Pharmaceutical БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
57	MN-MMRA - 300020634	Биеийн бүх хэсгээр харшлын тууралт гарч, загатнана.	Сүрьеэгийн эмчилгээнд	HRZE	HRZE	Macleods Pharmaceutical БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
58	MN-MMRA - 300020635	биеэр харшлын тууралт гарч, загатнана, амьсгаадна.	Сүрьеэгийн эмчилгээнд	Rifampicin-300mg	Rifampicin-300mg	Macleods Pharmaceutical БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
59	MN-MMRA - 300020636	Арьсаар тууралт гарч,загатнан, улайж цочирсон	Холестистозэктомиаа	Меропенем	Меропенем	Ө/У	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
60	MN-MMRA - 300020637	Мэдээ алдаагүй	Сигнал мэдээ алдуулалт	Буливакайны гидрохлорид	Гипербуливакайн	Айвиго эмийн үйлдвэр	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)

61	MN-MMRA - 300020638	Хоолой боож, цээж давчдан, амьсгал давхацсан	S30.0 Зоонуруу ба аарцгийн няцрал, S73.1 Түнхний үе ба холбоос сунах чинэрэх	Метамизол натри Дифенгидрамин	Аналгин, Димедрол	Нахиа эмийн үйлдвэр,Цомбо эмийн үйлдвэр	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
62	MN-MMRA - 300020639	Тууралт гарч, загтнасан	MRSA, хатиг буглаа	Ванкомицин	Ванкомицин	Kraspharma JSC ОХУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
63	MN-MMRA - 300020640	Тууралт	Мэс заслын дараах халдвараас сэргийлэх	Цефтриаксон	Цефтриаксон	Kraspharma JSC ОХУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
64	MN-MMRA - 300020641	Бүх биеэр улаан гүвдрүү гарч, маш хүчтэй хавдсан, маш их загатнасан, хөдөлгөөн хязгаарлагдсан.	Өвдөлт намдаах	Ибупрофен	Ибупрофен	Ө/Ү	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
65	MN-MMRA - 300020642	Биеэр тууралт гарсан.	Үе мөчний өвдөлт	Диклофенак	Диклофенак	Ө/Ү	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
66	MN-MMRA - 300020643	Биеэр тууралт гарч, Гар бадайрсан.	Үе мөчний өвдөлт	Диклофенак	Диклофенак	Padra.Dist. Vadodata	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
67	MN-MMRA - 300020644	Дотор муухайрч, зүрх дэлгсэн	streptococcus agalatiea / хөөмийн арчдас /	цефтриаксон 1гр	цефтриаксон 1гр	Kraspharma JSC ОХУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
68	MN-MMRA - 300020645	Нүүр улайсан	Цэр ховхлох	Сальбутамол	Нобивент плюс	Noble wellness pvt.LTD	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
69	MN-MMRA - 300020646	Биеэр улаан тууралт гарсан, хоолой бачуурсан, нүд зовхи орчим хавдсан.	Онош тодруулах	Гадовист	Гадовист	Bayer AG Герман улс	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
70	MN-MMRA - 300020647	Бүх биеэр улаан тууралт гарсан	Үрэвсэл дарах	Амоксициллин 1000мг	Амоксициллин 1000мг	Sandoz GmbH, Kundl	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
71	MN-MMRA - 300020649	Нүүр хүзүү халуун оргисон	Ө/Ү	Никотины хүчил1%-1.0	Витамин ПП	Айвико эмийн үйлдвэр	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
72	MN-MMRA - 300000614	Дотор муухайрч бөөлжсөн, хамаг бие халуу оргих	Хепатит	Л-орнитин-Л-аспарат Hepargard	Хепатард	United biotech БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)

73	MN-MMRA - 300020654	Царай цонхийно, Амьсгал давчдана Дагжин чичрээнэ Ууц нуруугаар өвдөнө Гуяны арьс эрээтэнэ	Мэс заслын дараах халдвараас сэргийлэх	Цефазолин	Цефазолин	Нахиа Импекс ХХК	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
74	MN-MMRA - 300020655	Дотор муухайрах	өндгөвчний дахисан хавдар	Доксорубицин	Ай Докс	Getwell Pharmaceutical БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 8)
75	MN-MMRA - 300020657	Зовхи, уруул хавагнасан	Бусад хүндрэлтэй ил шамбарам 184.4	Диклофенак	Рапи-Лелиф инжекшн	Flagship Biotech international	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
76	MN-MMRA - 300020658	Гар гэдсээр цайвар гүвдрүүтэй тууралт гарсан, нүүр уруул хавагнасан	Уушгины бусад гэмтэл /S27.3/	Диклофенак	Рапи-Лелиф инжекшн	Flagship Biotech international	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
77	MN-MMRA - 300020659	Толгой эргэх, даралт унасан 4мөч суларсан	Тархи толгой өвдөлт	ГИНКО БИЛОБА	Гинварен	Hawon Pharmaceutical Corporation	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Байж болох (Наранжо 4)
78	MN-MMRA - 300020660	Хоолой боож, бачуурсан	Z39.2	Никотинамид + Пиридоксины гидрохлорид + Фолийн хүчил + Цианокобаламин + Натрийн пантотенат + Биотин + Натрийн аскорбат + Тиамин + Рибофлавин	Солувит Н	Fresenius Kabi SSPC БНХАУ	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
79	MN-MMRA - 300020662	Цээж давчдан, амьсгалахад хүндрэлтэй болсон	Хөхний хорт хавдрын эмчилгээ	Доцетаксол	Доцету	onco llc	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Илэрхий (Наранжо ≥ 9)
80	MN-MMRA - 300020663	Арьс туурсан	Сувганцрын завсрын эдийн цочмог нефрит	Цефтриаксон	Цефтриаксон	Красфарма, ОХУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
81	MN-MMRA - 300020664	Ходоод халуун оргино	Эмчийн заалтаар булчиад	Никотины хүчил	Витамин PP	Айвико	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)

82	MN-MMRA - 300020665	Нойргүйдэж, ядарсан	Хэм алдагдал	Атеналол	Атеналол Денк	Denk farma	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
83	MN-MMRA - 300020653	Арьс улайж, 15мм хавдсан	Үрэвслийн эсрэг	Цефазолин	Цефазолин	ПАО Синтез ОХУ		Сорил	
84	MN-MMRA - 300020666	хэсэг газар улайж, жижиг тууралт үүссэн. 3-3,5 мм	Онош тодруулах	Йопромид	Ультравист	Bayer (Герман улс)		Сорил	
85	MN-MMRA - 300020675	Арьсан дээр гүвдүүт тууралт гарч, толгой эргэж, дотор муухайрсан	Онош тодруулах	Йопромид	Ультравист	Bayer (Герман улс)		Сорил	
86	MN-MMRA - 300020667	Хэсэг газар улайж жижиг тууралт үүссэн 3-3,5 мм	Онош тодруулах	Йопромид	Ультравист	Bayer (Герман улс)		Сорил	
87	MN-MMRA - 300020668	Хэсэг газар улайж жижиг цэгэн тууралт гарсан	Онош тодруулах	Йопромид	Ультравист	Bayer (Герман улс)		Сорил	
88	MN-MMRA - 300020669	Дотор муухайрч, бөөлжин, толгой өвдөж, нойргүйдэн, арьсны тууралт гарч, Ангиоздема (нүүр уруул хэл хавагнах)	Pneumonia	Кларитромицин	Фромилид	KRKA	Хүнд (Түвшин 4)	Б хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
89	MN-MMRA - 300020670	Дотор муухайрч, тууралт гарч, загатнасан	Commotia cerebri	Цитиколин	Брайнакт	PT Dankos Farma, Kalbe company,	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
90	MN-MMRA - 300020672	Нүүр, хүзүү хэсгээр улайж, хорсож, загатнасан.	Захын цусан хангамж сайжруулах	Никотины хүчил	Витамин PP	Нахиа Импекс ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
91	MN-MMRA - 300020673	Толгой дүүрэх, нүүр болон бие мөчдөөр улаан тууралт гарч, загатнасан	J45.9	Цефотаксим	Цефотаксим	Daewon Pharm БНСУ	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Илэрхий (Наранжо ≥ 9)
92	MN-MMRA - 300020674	Дотор давдаж, ам хатаж хуурайшсан	Haemorrhoids	Диосмин	Diosmin /Prepain/	ILDONG	Хөнгөн (Түвшин 2)	Б хэлбэр	Байж болох (Наранжо 4)
93	MN-MMRA - 300020676	Амьсгал давчдан, тасралтгүй ханиалгасан	Тархины цусан хангамжийн дутагдал	Инозин + Никотинамид + Рибофлавин + Сукцины уламжлал	Цитофлавин	OXY, Scientific Technological Pharmaceutical Firm « POLYSAN », LTD	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)

94	MN-MMRA - 300020678	Нүүр халуу оргисон	J44	Никитоны хүчил	Витамин PP	Цомбо фарм ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
95	MN-MMRA - 300020679	Хэвлийгээр базалж, хөлс ялгарсан	G44	Никитоны хүчил	Витамин PP	Цомбо фарм ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
96	MN-MMRA - 300020680	Бөөлжиж, толгой эргэсэн	Эдийн шинжилгээ авах мэс засалд орсоны дараах 7-8 балл хүчтэй өвдөлт.	Трамадолын гидрохлорид	Трамадол	IVCO ХХК	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
97	MN-MMRA - 300020681	Харшлын урвал		Глицин + Цистеин + Чихэр өвс	Стронгер Нео- Минофаген Ц	Minorhagen Pharmaceutical Co.,Ltd	Хүнд (Түвшин 4)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
98	MN-MMRA - 300020682	Нүүр улайж, дотор муухайрч огиудас хүрч, толгой эргэсэн.	N11	Цефтриаксон	Цефтриаксон	Reyoung Pharmaceutical Co.,Ltd	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
99	MN-MMRA - 300020684	Ухаан алдсан	Үр хөндүүлэх	Мифепристон + Мизопростол	Мариприст	Acme Formulation LTD	Ноцтой (Түвшин 5)	Б хэлбэр	Байж болох (Наранжо 4)
100	MN-MMRA - 300020685	Гүвдрүүт тууралт гарч, загатнасан	Үтрээний үрэвсэл	Метронидазол	Метронидазол	Otto Pharmaceutical Industries	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
101	MN-MMRA - 300020687	Бүх биеэр тууралт гарсан	Ханиад	Инозин пранобекс	Гроприносин	Геден рихтер	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
102	MN-MMRA - 300020688	Хоолой сэргэж, дотор муухайрч, уруул бадайрсан.	Бөөр шээс замын халдвар	Флуконазол	Флуконазол	Мөнхийн тух ХХК	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
103	MN-MMRA - 300020689	Дотор муухайрч ухаан баларгаж амнаас хөөс гарсан.	Бруцеллёз	Цефотаксим	Цефотаксим	Нахиа Импекс ХХК	Ноцтой (Түвшин 7)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
104	MN-MMRA - 300020690	Сорил тавиад харшилсан. Эмчлүүлэгчид хэрэглээгүй, шинжилгээнд ороогүй. Вакумд соруулаад 2 цаг болоод тунадас үүссэн.	Онош тодруулах зорилгоор	Йопамидол	Памирей 300	Dongkook pharmaceutical Co.,Ltd		Сорил	
105	MN-MMRA - 300020691	Бүх бие загатнаж, улаан тууралт гарсан	Үрэвслийн эсрэг	Ванкомицин	ванкомицин 1,0	Kraspharma JSC	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)

106	MN-MMRA - 300020692	Анафилаксийн шок	Мэс заслын өмнөх халдвараас сэргийлэх	Цефазолин	Цефазолин	Нахиа Импекс ХХК	Ноцтой (Түвшин 5)	Эмийн эмчилгээний асуудал
107	MN-MMRA - 300020693	Анафилаксийн шок	Мэс заслын өмнөх халдвараас сэргийлэх	Цефтриаксон	Цефтриаксон	Kasparharma JSC	Ноцтой (Түвшин 5)	Эмийн эмчилгээний асуудал
108	MN-MMRA - 300020694	Арьсны тууралт гарч, загатнан, шалбарсан	Чихрийн шижин 2 хэлбэр	Дапагглифлозин 10мг	Форзига	Astrazeneca	Хүнд (Түвшин 4)	Үнэмшилтэй (Наранжо 7)
109	MN-MMRA - 300020695	Дотор давчдан, нүүр улайсан	Prostate cancer	Доцетаксел	Доцетаксел	sichsan huiyu pharmaceutical coltol	Хөнгөн (Түвшин 2)	Үнэмшилтэй (Наранжо 7)
110	MN-MMRA - 300020696	Арьс улайж загатнаж, амьсгал бачуурсан	Ходоодны хорт хавдар	Фторурацил	Рацивел	Getwell pharmaceuticals	Хөнгөн (Түвшин 2)	Үнэмшилтэй (Наранжо 7)
111	MN-MMRA - 300020697	Арьс улайж, загатнасан	Умайн хүзүүний хавдар	Карбоплатин	Карбодекс	Deva Holding A.Ş	Хөнгөн (Түвшин 2)	Үнэмшилтэй (Наранжо 7)
112	MN-MMRA - 300020698	Бие тавгүйрхэж, хүйтэн хөлс гарсан.	Үрэвслийн эсрэг хавдар	Цефотаксим	Цефотаксим	Нахиа Импекс ХХК	Хөнгөн (Түвшин 2)	Үнэмшилтэй (Наранжо 5)
113	MN-MMRA - 300020699	Арьсны харшил тууралт, загатнаа	Цээжний бах, хэрлэг төст артрит	Никитоны хүчил	Витамин PP	Цомбо фарм ХХК	Хөнгөн (Түвшин 2)	Үнэмшилтэй (Наранжо 7)
114	MN-MMRA - 300020701	Гарын хуруу, алга хөөж хавагнаж, улайж, загатнасан	Хэсэгчилсэн уналт	Карбамазепин	Эпилиптор	Whan in Pharm. Co., Ltd	Хөнгөн (Түвшин 2)	Үнэмшилтэй (Наранжо 6)
115	MN-MMRA - 300020707	Чичирч дагжсан, гар хөл яангинасан	J18.9	Цефотаксим	Цефотаксим	Нахиа Импекс ХХК	Хөнгөн (Түвшин 2)	Үнэмшилтэй (Наранжо 7)
116	MN-MMRA - 300020708	Дотор муухайрах хоол унданд дургүй бөөлжих	Сүрьеэ	RHZE	RHZE	SVIZERA INDIA	Хүнд (Түвшин 3)	Үнэмшилтэй (Наранжо 7)
117	MN-MMRA - 300020709	Дотор муухайрах бөөлжих хоол унданд дургүй ядрах аюулхай өвдөх	Сүрьеэ	RHZE	RHZE	SVIZERA INDIA	Хүнд (Түвшин 3)	Үнэмшилтэй (Наранжо 7)
118	MN-MMRA - 300020710	Амьсгаадан, найтааж, ногоон цэр гарна, уруул хөхөрнө, хавдана	Зүрхний хурмал дутагшил	Цефотаксим	Цефотаксим	Нахиа Импекс ХХК	Хүнд (Түвшин 3)	Үнэмшилтэй (Наранжо 7)

119	MN-MMRA - 300020711	Дотор муухайрах, огиулах	N18.0 Бөөрний өвчний төгсгөлийн шат	Левифлоксацин	Dai HAN Pharm. co.LTD БНСУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
120	MN-MMRA - 300020712	Гарын шууны арьсан дээр жижиг тууралт гарч загатнасан	шингэн дутагдал, хордлого тайлах	Калийн хлорид + Кальцийн хлорид + Глюкоз	IVCO тарилгын эмийн үйлдвэр	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
121	MN-MMRA - 300020713	Ууц нуруу хэсгийн арьсан дээр тууралт гарч, халуу оргисон. Хатуурч хавагнасан. Харшлын тууралт улааж ихсэж дээшээ нурууруу өгссөн.	Гломерулонефрит- Glomerulonephritis	Дапаглицлозин	Моносфарм Трейд ХХК	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
122	MN-MMRA - 300020715	Дотор муухай оргих, хий огих	K63.5 онош	Амин хүчлүүд + Глюкоз + Тосны хүчлүүд	Astra Zeneca Pharmaceuticals LP, USA	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
123	MN-MMRA - 300020716	Хэвлий цээжээр улаан гүвдрүү тууралт гарч загатнасан.	K63.5	Амин хүчлүүд + Глюкоз + Тосны хүчлүүд	KRKA	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
124	MN-MMRA - 300020717	20 цагт ханиалгах хэл ээдрэх хоолой бачуурах гар хөл хүйт даах шинж тэмдэг илэрсэн	SPCT ХОРТ ХАВДРЫН ЭСРЭГ	Иринотекан	NAP		А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
125	MN-MMRA - 300020718	Дотор муухайрч, бөөлжис цутгасан	K63.5 онош	Амин хүчлүүд + Глюкоз + Тосны хүчлүүд	Denk	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
126	MN-MMRA - 300020719	Загатнаа	Хавдрын эсийг устгах	Цитарабин	Swisse	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
127	MN-MMRA - 300020721	Хаван, тууралт, загатнаа	Brain MRI	Меглюмин	Dongkook pharmaceutical Co.,Ltd		Сорил	
128	MN-MMRA - 300020722	Арьсны тууралт, загатнаа	Brain MRI	Меглюмин	Dongkook pharmaceutical Co.,Ltd		Сорил	

129	MN-MMRA - 300020723	Судас дагаж улайж, загатнасан	Ходоодны шарх	Левовфлоксацин	Леванике 0,5%	Realcade Lifescience Pvt. Ltd БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
130	MN-MMRA - 300020724	Гарын алга загатнаж, улайсан	Пневмони	Левовфлоксацин	Леванике 0,5%	Realcade Lifescience Pvt. Ltd БНЭУ	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
131	MN-MMRA - 300020725	Ханиалгаж, судас дагаж улайж, загатнасан	Пневмони	Левовфлоксацин	Леванике 0,5%	HUMANIQUE	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
132	MN-MMRA - 300020726	Хүйтэн хөлс гарч чичирсэн, Артерийн даралт 70/40. Пульс 110 болж өөрчлөгдсөн	C-56	Карбоплатин	Карбодекс	Deva Holding Турк Улс	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
133	MN-MMRA - 300020727	Биеэр тууралт гарч, амьсгаадах, бачуурах шинч тэмдэг илэрч зүрхээр өвдсөн.	Зүрхээр хатгуулах шинж тэмдэг	Допамин	Кардидоп	Flagship Biotech International БНЭУ	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
134	MN-MMRA - 300020730	Гар бадайрч, хоолой хавагнаж, бие загатнасан	C 34.9	Цисплатин	Цифинту	Onko Ila3 Sanaui ve Tiscaret A.Ş. БНТУ	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
135	MN-MMRA - 300020731	Харшлын урвал илэрсэн	N11	цефотаксим 1гр	Цефотаксим 1гр	Нахиа Импекс ХХК			Сорил
136	MN-MMRA - 300020732	Харшлын урвал илэрсэн	N11	Цефазолин	Цефазолин	Нахиа Импекс ХХК			Сорил
137	MN-MMRA - 300020733	Амьсгал давхцаж бачуурч, дотор муухай оргих, бөөлжис хүрсэн	Хэм алдалт	Глюкоз + Калийн хлорид	Калийн холимог шингэн	Айвико тарилгын шингэний үйлдвэр	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
138	MN-MMRA - 300020734	Арьсны тууралт гарч, загатнасан	J-20 N-11	цефотаксим 1гр	цефотаксим 1гр	Нахиа Импекс ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 8)
139	MN-MMRA - 300020735	Биеийн бүх хэсэг улайж загатнасан	Хордлого тайлах	Натрийн лактат + Натрийн хлорид + Калийн хлорид + Кальцийн хлорид	Рингер лактат 250мл	Айвико тарилгын шингэний үйлдвэр	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 8)

140	MN-MMRA - 300020736	Арьсны тууралт гарч, хорсож, загатнасан	Хелико бактерийн эмчилгээ	Кларитромицин	Кларитромицин	Ө/Ү	Хүнд (Түвшин 4)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
141	MN-MMRA - 300020737	Дотор муухай оргиж бөөлжсөн, зүүн талын дээд зовхи цэврүүтэж улайж хавдсан	Мэс заслын халдвараас сэргийлэх	цефотаксим 1гр	цефотаксим 1гр	Нахиа Импекс ХХК	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
142	MN-MMRA - 300020738	Толгойруу халуу оргиж, өвдсөн, бие чичирч, дотор муухайрсан	Архаг астма	Аминофиллин	Эуфиллин	Цомбо фарм эмийн үйлдвэр	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
143	MN-MMRA - 300020739	Толгой эргэж, өвдсөн	Уураг алдалт	Цефазолин	Цефазолин	Нахиа Импекс ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
144	MN-MMRA - 300020740	Зүүн гарын дотор тал улайх, хавдсан, бэрсүүтсэн	Экзем	Ванкомицин	Ванкомицин	Sintez JSC			Сорил
145	MN-MMRA - 300020741	Бүх бие халуу оргиж, булчин хэсгээр улайж, тууралт гарсан.	Ө/Ү	Никотины хүчил	Витамин PP	Нахиа Импекс ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
146	MN-MMRA - 300020742	Хоолой боож, бачуурсан	C40.0	Доцетаксел	Доцетаксел	onko llc	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
147	MN-MMRA - 300020743	Хэвлийгээр өвдөж, арьс загатнасан	Ерөндөг тавиулах	Метронидазол + Миконазол	Метромикон форте	ООО ФАРМАПРИМ, Молдав	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 8)
148	MN-MMRA - 300020744	Хэсэг газрын хариу урвал	Мэдрэлийн булчингийн чангарал	Толперизон + Лидокаин	Мидокалм	Геден Рихтер ТГ, Унгар Улс	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
149	MN-MMRA - 300020745	Цэврүүт тууралттай загтнах улайх хөндүүрлэх шинж тэмдгүүдтэй	Шүүдний өвдөлт	Ибупрофен	Ибупрофен денк 400мг	ДЕНК ФАРМА, Герман Улс	Хүнд (Түвшин 4)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)
150	MN-MMRA - 300020746	Биеэр жижиг тууралт гарна, бөөлжиж, гүйлгэсэн	Уушгины сүрьеэгийн улмаас	H75 R150 E275 Z400	H75 R150 E275 Z401	Svizzera Labs Private Limited, Энэтхэг	Хүнд (Түвшин 4)	А хэлбэр	Илэрхий (Наранжо ≥ 9)
151	MN-MMRA - 300020747	Дотор муухайрч, арьсны тууралт гарсан	элэгний хавдар, онош тодруулахаар эмчийн заалтаар КТГ	Йопромид	Ультравист 300	Bayar AG	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Илэрхий (Наранжо ≥ 9)

152	MN-MMRA - 300020748	Дотор муухай оргих толгой эргэх	N10	Глюкоз + Калийн хлорид	Калийн холимог шингэн	ЭНТО ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
153	MN-MMRA - 300020749	Хөлс чийхарч, толгой эргэж, нүд бүрэлзсэн	I25	Глюкоз + Калийн хлорид	Калийн холимог шингэн	ЭНТО ХХК	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
154	MN-MMRA - 300020750	Даралт буурч, дотор муухайрч, пульс өөрчлөгдсөн	N10	Цефатоксим	Цефатоксим	Ө/Ү	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 7)
155	MN-MMRA - 300020751	2 хөлийн үзүүр बादайрч, чинэрэн, өвдөнө	Сүрьеэгийн эмчилгээнд	Линезолид	Линезолид	LUPIN LTD	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
156	MN-MMRA - 300020752	Тууралт гарсан	Өвчин намдаах	Метамизол натри	Анальгин	Ө/Ү	Хөнгөн (Түвшин 2)	А хэлбэр	Илэрхий (Наранжо ≥ 9)
157	MN-MMRA - 300020753	Дотор муухайрч, цээж давчдан, амьсгал бачуурна.	SPCT due to advanced rectal cancer LNS lung and liver nuts CT3N2M1 st-4	Иринотекан	Иринотекан гидрохлорид	Onko llac	Хүнд (Түвшин 4)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
158	MN-MMRA - 300020754	Дотор муухайрч ханиалгасан, амьсгал давчдсан, зүрх дэлссэн	Үрэвслийн эсрэг	Цефозолин	Цефозолин	Нахиа Импекс ХХК	Хүнд (Түвшин 4)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 6)
159	MN-MMRA - 300020756	Нүд хавагнаж, тууралт гарсан	Онош тодруулах	Йопромид	Ультравист 300	Bayer AG	Хүнд (Түвшин 3)	А хэлбэр	Үнэмшилтэй (Наранжо 5)

МОНГОЛ УЛСАД БҮРТГЭГДСЭН ГАЖ НӨЛӨӨНИЙ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНХААРУУЛГА, СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Апротинин эмийн гаж нөлөөний эрсдэлээс сэргийлэх

Манай улсад Унгар Улсын Геден Рихтер үйлдвэрлэгчийн Апротинин (Гордокс) 100000КИЕ тарилгын эмийн хэрэглээтэй холбоотой гаж нөлөөний ноцтой тохиолдол бүртгэгдсэний дагуу 2023 онд Монгол Улсад бүртгэлтэй Апротинин агуулсан эмийн идэвхтэй тандалт судалгааг хийж, үр дүнг Эм судлалын салбар зөвлөл болон Хүний эмийн зөвлөлийн хурлаар тус тус үе шаттай хэлэлцүүлсний дүнд гарсан зохицуулалтын шийдвэрүүдийг хүргүүлж байна. Үүнд:

1. Үйлдвэрлэгчээс ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн ба Эм судлалын салбар зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 07 дугаар хурлаар тус эмийн хэрэглэх зааварт өөрчлөлт оруулснаар “Нойр булчирхайн цочмог үрэвсэлд” гэх заалт хасагдсан.
2. Хүний эмийн зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрээр Апротинин (Гордокс) 100000КИЕ тарилгын эмийг үйлдвэрлэгчийн хүсэлтээр Монгол Улсын эмийн бүртгэлээс хасах шийдвэр гарсан.

Иймд Апротинин (Ренонтрикал) 10000МЕ тарилгын эмийг дээрх хасагдсан заалтаар хэрэглэхгүй бөгөөд Апротинин (Гордокс) 100000КИЕ тарилгын эмийг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, худалдан борлуулах болон эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх боломжгүй болсон тул нийт эмнэлгийн мэргэжилтнүүд эмнэлгийн тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний сонголтод анхааралтай хандана уу.

Цитофлавин эмийн гаж нөлөө

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд өргөн хэрэглэгдэж буй Цитофлавин (Инозин+Никоти намид+Рибофлавин+Сукцины хүчил) тарилгын уусмал эмийн хэрэглээтэй холбоотой 2024 оны байдлаар гаж нөлөөний 6 тохиолдол бүртгэгдээд байна.

Эдгээр тохиолдол нь эм-гаж нөлөө хоорондын шалтгаан хамаарлын үнэлгээгээр Илэрхий болон Үнэмшилтэй, гаж нөлөөний хэлбэрийн хувьд Б хэлбэр-1, А хэлбэр 5, хүнд, хөнгөний зэргийн Хартвигийн шалгуураар хөнгөн-2, хүнд-3 болон ноцтой-1 тохиолдол байна.

Уг асуудлыг Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцээд илэрсэн гаж нөлөөний шинж тэмдгүүд нь ховор болон маш ховор ангилалд хамаарахаар хэрэглэх зааварт тусгагдсан ч эмийн хэрэглээнээс үүдэлтэй буюу тарилгын уусмалын хурд хэтэрсний улмаас гаж нөлөөний эрсдэлийг нэмэгдүүлсэн байх боломжтой гэж үзсэн.

Иймд тус хурлын шийдвэрийн дагуу эрсдэлээс сэргийлэх дараах арга хэмжээний зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тус эмийг тарьж хэрэглэх үедээ хурдыг тохируулах, эмийн хэрэглэх зааврын дагуу аюулгүй хэрэглээг мөрдлөг болгох асуудлын хүрээнд эмнэлэг бүр эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт, мэдээллийг хийх.

Өөрийн эмнэлгийн тусламж үйлчилгээний онцлогийн хүрээнд өргөн хэрэглэгддэг эм, биобэлдмэлийн сэргийлэх боломжтой (эмийн эмчилгээний алдаа) гаж нөлөөний тохиолдлыг бууруулах чиглэлд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Натрийн салицилат

Натрийн салицилатын 10%-100 мл тарилгын уусмалын тунг хэтрүүлэн дулаар хэрэглэсэнтэй холбоотой чих шуугих, сонсгол алдагдах зэрэг салицилатын хордлогын шинж тэмдэг нэгэн зэрэг 3 үйлчлүүлэгчид илэрсэн тохиолдол бүртгэгдсэн.

Энэхүү тохиолдол нь эмийн эмчилгээний алдаанаас үүдэлтэй бөгөөд урьдчилан сэргийлж болохуйц гаж нөлөөний тохиолдол юм. Иймд тус тарилгын уусмалын тунг 5-10мл-ээс хэтрүүлэхгүй, дулаар тарьж хэрэглэхгүй байх эмийн заавар дах анхааруулга хэсгийг мөрдлөг болгож ажиллах;

Сэргийлэх боломжтой гаж нөлөөний эрсдэл

Сүүлийн 2 жилийн байдлаар үндэсний мэдээний санд бүртгэгдсэн нийт тохиолдлын 13,5% буюу 10 тохиолдол тутмын 1 нь эмийн хэрэглээнээс үүдэлтэй буюу эмийн эмчилгээний, сувилахуйн тусламж үйлчилгээний алдаатай холбоотой байна.

Нийтлэг тохиолдолд тарилгын уусмал, дуслын шингэн, антибиотик эмийн хэрэглээтэй холбоотой үүсэж байна.

Шалтгааны тухайд дараах нийтлэг алдаа бүртгэгдэж байгаа тул эрүүл мэндийн байгууллагууд эрсдэлээс сэргийлэн хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг тогтмол, үр дүнтэй зохион байгуулж ажиллахад анхаарах шаардлагатай. Үүнд:

- Үйлчлүүлэгчээс харшилтай эм, тарианы тухай асуумж дутаа авах;
- Харшлын сорилын тэмдэглэгээг өвчний түүхэнд тэмдэглэхгүй байх;
- Өвчний түүхэнд тэмдэглэсэн сорил эерэг тэмдэглэгээг анзаарахгүй эмчилгээний тунг эхлүүлэх;
- Тарилгын нунтгийн найруулах уусмалыг буруу сонгох;
- Эмийн үл нийцлийг харгалзахгүй хийх;
- Эмийн хэрэглэх заавар, удирдамжийг баримтлахгүй заалтын бус эмчилгээ бичих;
- Нэг дор судсаар олон тарилгын уусмалыг ар араас нь өндөр концентранцитайгаар шахах;
- Анафилаксийн шокийн үеийн амилуулах яаралтай тусламжийн бэлэн байдал хангагдаагүй;

Хууль бус эмийн хэрэглээнээс үүдэлтэй гаж нөлөө

Манай үндэсний мэдээний санд 2024 онд Дапаглифлозин олон улсын нэршил бүхий Форзига 10мг эмтэй холбоотой гаж нөлөөний 2 тохиолдол орон нутгийн хувийн эмнэлгээс мэдээлэгдсэн. Энэхүү тохиолдлыг Эм судлалын салбар зөвлөлийн 2024 оны 04 дүгээр хурлаар хэлэлцүүлэхэд хүнд, хөнгөний зэргийн хувьд "Хүнд (түвшин 4)", "Б хэлбэр"-ийн тохиолдол гэж үнэлсэн.

Тус эм нь Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэлтэй АНУ-ын Астразенека үйлдвэрлэгчийн Дапаглифлозин олон улсын нэршил бүхий "Форсига" 10мг эмнээс бүртгэлийн загвар зөрүүтэй буюу бүртгэлгүй эм байсан.

Дээрх тохиолдол нь иргэн эмийн сангаас худалдан авч хэсэг хугацаанд хэрэглэсний дараа арьсан дээр тууралт гарах, загатнах, шархлах шинж тэмдэг удаан үргэлжилснээс эмнэлгийн тусламж авахаар эмнэлэгт хандсаны дагуу манайд мэдээлэгдсэн тохиолдол юм.

Түүнчлэн цахим орчинд хувь хүмүүс өөрийн фэйсбүүк хуудсаар дамжуулан тус эмийг бөөнөөр, хямд худалдан борлуулах тухай зарыг түгээж, худалдаалж байгаа нь Зар сурталчилгааны тухай хуулийн 13.1, 13.2 заалтуудыг зөрчиж байна.

Тиймээс дээрх хууль бус эмийн хэрэглээнээс үүдэлтэй үйлчлүүлэгчид учрах аюулгүй байдлын эрсдэлээс сэргийлж, үйлчлүүлэгчийн эмийн сонголт, хэрэглээнд хяналт тавьж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллана уу.

ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС МЭДЭЭЛЭГДСЭН ЭМИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Д.Ганчимэг ЭЗУ-ны магистр ЭЭХХЗГ-ын
/Хуурамч, стандартын бус эмийн тандалт, судалгааны
асуудал хариуцсан мэргэжилтэн/

WHO, MEDICAL PRODUCT ALERT N°01/2022: FALSIFIED (CONTAMINATED) USP/EP PROPYLENE GLYCOL

Пакистан Улсад DOW үйлдвэрлэгчийн хуурамч USP/EP PROPYLENE GLYCOL бүтээгдэхүүн илэрсэн.

DOW USP/EP ПРОПИЛЕНГЛИКОЛЬ нь эмийн болон бусад үйлдвэрлэлд ашиглагддаг түүхий эд (туслах бодис) бөгөөд эмийн үйлдвэрлэлд хэрэглэхдээ Америк болон Европын фармакопейн (USP/EP) стандартыг баримталдаг.

ДЭМБ-аас бохирлогдсон шингэн эмийн хэлбэрийн талаарх 7 сэрэмжлүүлгийг хүргэж байсан.

2023 оны 12 дугаар сард ДЭМБ-ын Эрүүл мэндийн бүтээгдэхүүний сэрэмжлүүлгийн дагуу Пакистан Улсын Эмийн Зохицуулалтын Байгууллага нь ууж хэрэглэх шингэн эмүүдэд хяналт шалгалтыг хийсэн байна.

Уг хяналт шалгалтаар пропиленгликолийн сэжигтэй тохиолдлыг илрүүлсэн ба дээжийг тус улсын Эмийн төв лабораторид шинжлэхэд этиленгликоль 0.76%-100% хүлээн зөвшөөрөгдөөгүй хэмжээтэй агуулагдаж байсныг тогтоосон.

Пакистан Улсын Эмийн Зохицуулалтын Байгууллага 2024 оны 01 дүгээр сараас 03 дугаар сард "DOW USP/EP PROPYLENE GLYCOL"-ийн бохирдлогдсон 5 цувралын талаарх 3 сэрэмжлүүлгийг гаргасан. Тэдгээр сэрэмжлүүлэгт заасан болон ДЭМБ-ын энэхүү сэрэмжлүүлэгт дурьдсан түүхий эд нь хуурамч бөгөөд, тэрхүү түүхий эдийг үйлдвэрлэж, нийлүүлээгүй гэж DOW мэдэгдсэн. Тиймээс эдгээр туслах бодисын чанар, аюулгүй байдлыг батлах боломжгүй.

Энэхүү сэрэмжлүүлэгт дурдсан Пропиленгликоль нь зориуд хуурамчаар үйлдсэн хаяг шошготой байсан ба их хэмжээний Этиленгликоль агуулагдаж байгаа бөгөөд ууж хэрэглэсэн тохиолдолд хордуулах боломжтой юм.

Эдгээр түүхий эдийг албан бус болон зохицуулалтгүй зах зээлээр дамжуулан бусад улс оронд түгээсэн байж болзошгүй.

Эрсдэлүүд

Диэтиленгликоль ба Этиленгликоль нь хүний биед хортой бөгөөд үхэлд хүргэх аюултай. Энэхүү сэрэмжлүүлэгт дурьдсан стандартын бус бүтээгдэхүүнүүд нь аюултай бөгөөд, ялангуяа хүүхэд ууж хэрэглэсэн тохиолдолд ноцтой гаж нөлөө үзүүлж, цаашилбал үхэлд хүргэх боломжтой. Хэрэглэснээр хэвлийгээр өвдөх, бөөлжих, суулгах, шээс хаагдах, сэтгэцийн өөрчлөлт, толгой өвдөх, бөөр гэмтээх, цаашилбал үхэлд хүргэх аюултай.

Үйлдвэрлэгчид, ханган нийлүүлэгчид, зохицуулалтын байгууллагуудад өгөх зөвлөгөө

Эм үйлдвэрлэгчид зөвшөөрөлтэй ханган нийлүүлэгчдээс шаардлага хангасан түүхий эдийг авах ёстой. Пропиленгликоль, сорбитол, глицерин/глицерол, этиленгликоль ба/эсвэл диэтиленгликолиор бохирдох эрсдэлтэй түүхий эд агуулсан сироп эм үйлдвэрлэгчдийг ДЭМБ-ын эм үйлдвэрлэлийн зохистой дадлыг дагаж мөрдөхийг анхааруулж байна.

Үйлдвэрлэгчдэд шингэн эмийн үйлдвэрлэлд ашиглаж буй туслах бодисын цуврал бүрийг үйлдвэрлэлд ашиглахын өмнө этиленгликоль ба диэтиленгликолийн шинжилгээг хийхийг зөвлөж байна.

Диэтиленгликоль, этиленгликолиор бохирлогдсон хүүхдийн эмийг шинжлэх шинжилгээний аргуудыг боловсруулсан. Хийн хроматографи (GC) үүнд тохиромжтой бөгөөд өргөн хэрэглэгддэг аналитик арга юм. Хийн хроматографиар шинжлэх боломжгүй тохиолдолд ДЭМБ Олон улсын фармакопайд 2 түвшний аргыг зөвлөсөн. Энэхүү аргаар шинжлэхэд эхлээд сэжиг бүхий дээжинд илрүүлэх шинжилгээг нимгэн үет хроматографийн (TLC) аргаар шалгадаг. Дараа нь сэжигтэй бохирлогдсон бүтээгдэхүүнийг Хийн хроматографийн аргаар баталгаажуулж болно.

ДЭМБ эдгээр бохирлогдсон түүхий эдэд өртсөн байж болзошгүй улс орон, бүс нутгуудын нийлүүлэлтийн сүлжээнд хяналт, шалгалтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна. Мөн албан бус болон зохицуулалтгүй зах зээлд тавих хяналтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.

Хүснэгт 1. ДЭМБ-ын сэрэмжлүүлэг №01/2024

Бүтээгдэхүүний нэр	DOW USP/EP PROPYLENE GLYCOL			
Үйлдвэрлэгч	Dow Chemical, Thailand Ltd	Dow Chemical Pacific (Singapore) Private Limited		Dow Chemical, Thailand Ltd
Цувралын дугаар	C815N3OR41	C815L44R41	C815L44R52	C856H85R55
Үйлдвэрлэсэн огноо	2023.03	мэдээлэгдээгүй	мэдээлэгдээгүй	2023.01.15
Хүчинтэй хугацаа	2025.03	мэдээлэгдээгүй	мэдээлэгдээгүй	2025.01.15
Илэрсэн байдал	Цувралын дугаар /жинхэнэ/	Цувралын дугаар /жинхэнэ/ Хүчинтэй хугацаа 2023.04	Цувралын дугаар /хуурамч/	Цувралын дугаар /хуурамч/
Пакистан				
Falsified batch C815N3OR41 Falsified batch C856H85R55 Falsified batch F8900L8PPD6				

Бүтээгдэхүүний нэр	PROPYLENE GLYCOL USP/EP
Үйлдвэрлэгч	Dow Europe, GmbH, Germany
Цувралын дугаар	F8900L8PPD6
Үйлдвэрлэсэн огноо	2023.02
Хүчинтэй хугацаа	2025.02
Илэрсэн байдал	цувралын дугаар /хуурамч/
	Пакистан

MEDICAL PRODUCT ALERT N°2/2024: FALSIFIED OZEMPIC (SEMAGLUTIDE)

ДЭМБ-аас Бразил (2023 оны 10-р сар), Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (2023 оны 10-р сар), Америкийн Нэгдсэн Улсад (2023 оны 12-р сар) зохицуулалт бүхий нийлүүлэлтийн сүлжээнд хуурамч OZEMPIC (семаглютид)-ийн 3 цуврал илэрсэн талаар 2024 оны 06 сард мэдээлсэн.

OZEMPIC (семаглютид) нь насанд хүрэгчид, өсвөр насныхан, 12-аас дээш насны хүүхдэд тохиолдох чихрийн шижингийн 2-р хэлбэрийн гипергликемийн эмчилгээнд зориулагдсан глюкагон төст пептид-1 (GLP-1) дарангуйлагч бүлгийн эм юм.

OZEMPIC-ийн үйлдвэрлэгч нь энэхүү сэрэмжлүүлэгт дурдсан эдгээр 3 цувралыг Novo Nordisk-д үйлдвэрлэгдээгүй тэдгээрийн танигдах байдал, гарал үүсэл хуурамч болохыг дараах байдлаар баталсан.

- LP6F832 цувралын дугаарыг хүлээн зөвшөөрөөгүй.
- 430834149057 серийн дугаартай NAR0074 цувралын дугаартай хосолсон хэлбэр нь үйлдвэрлэгчийн бүртгэлд байхгүй.
- MP5E511 цувралаар үйлдвэрлэсэн ч бүтээгдэхүүн нь хуурамч болохыг баталсан.

Эрсдэл

Хуурамч OZEMPIC-ийн тун буруу, аюултай бодисоор бохирлогдсон, үл мэдэгдэх эсвэл орц найрлагыг орлуулснаас өвчтөнд үзүүлэх эмчилгээ үр дүнгүй болох, магадгүй эрүүл мэндэд ноцтой эрсдэлтэй байж болзошгүй ба арьсан дор тарихад амь насанд аюул учруулж болно.

Эмнэлгийн мэргэжилтнүүд, зохицуулалтын байгууллага, олон нийтэд өгөх зөвлөгөө

Эмнэлгийн мэргэжилтнүүд аливаа гаж нөлөө, эмчилгээ үр дүн муутай, хуурамч хэмээн сэжиглэсэн тохиолдлын талаар Үндэсний зохицуулалтын байгууллагад мэдээлэх, Үндэсний зохицуулалтын байгууллага/эрүүл мэндийн байгууллагууд зах зээлд гарах зөвшөөрөл эзэмшигчдэд дэмжлэг үзүүлж, хуурамч бүтээгдэхүүнийг илрүүлэх, албан бус онлайн худалдаалж байгаа бүтээгдэхүүнд тавих хяналтыг нэмэгдүүлэх, эмийн бүтээгдэхүүнийг эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй ханган нийлүүлэгчдээс авахыг зөвлөж байна.

Хуурамч бүтээгдэхүүнийг таних арга:

1. Цувралын дугаар болон серийн дугаарыг шалгах.
2. Үзгийг шалгах. (хуурамч OZEMPIC-ийн тунг тохируулах үзэгний хуваарь буруу байх.)
3. Шошгыг үнэлэх. Шошго нь чанар муутай, үзгэнд шошгыг сайн наагаагүй байж магадгүй.
4. Үг үсгийн алдааг харах. Хайрцаг дээр үг үсгийн алдаатай байна.




Хүснэгт 2. ДЭМБ-ын сэрэмжлүүлэг №02/2024

Бүтээгдэхүүний нэр	OZEMPIC
Үйлдвэрлэгч	Novo Nordisk Farmaceutica do Brasil Ltda
Савлалт хаяглалт	Португал хэлээр
Цувралын дугаар	LP6F832
Хүчинтэй хугацаа	2025.11
Илэрсэн байдал	Бразил

Бүтээгдэхүүний нэр	OZEMPIC
Үйлдвэрлэгч	Novo Nordisk
Савлалт хаяглалт	Герман хэлээр
Цувралын дугаар	MP5E511
Хүчинтэй хугацаа	2025.07
Илэрсэн байдал	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс



Бүтээгдэхүүний нэр	OZEMPIC
Үйлдвэрлэгч	Novo Nordisk
Савлалт хаяглалт	Англи хэлээр
Цувралын дугаар	NAR0074
Хүчинтэй хугацаа	2025.11.30
Илэрсэн байдал	АНУ



Medical Product Alert N°3/2024: Falsified (contaminated) Oxymorphone Hydrochloride 40mg

Финланд улсын Эмийн агентлагаас 2024 оны 7-р сард хуурамч Оксиморфоны гидрохлоридын 40мг шахмал эмийг зохицуулалтгүй нийлүүлэлтийн сүлжээнд илрүүлсэн талаар ДЭМБ-д мэдээлсэн байна.

Оксиморфоны гидрохлорид нь дунд зэргийн хүчтэй өвдөлтийг эмчлэхэд хэрэглэгддэг хагас нийлэг опийн бүлгийн бодис юм. Лабораторийн шинжилгээгээр уг бүтээгдэхүүнд метонитазен агуулагдаж байсан нь тогтоогдсон.

Метонитазен нь хүчтэй сэтгэцэд нөлөөт опийн бүлгийн бодис бөгөөд албан ёсоор эмийн болон эмчилгээний зориулалтаар хэрэглэх нь зөвшөөрөгдөөгүй. Энэ бодис нь 2021 онд гаргасан ДЭМБ-ын “Эмийн хамаарлын шинжээчдийн хороо”-ны зөвлөмжийн дагуу мансууруулах бодисын I жагсаалтад багтаж, олон улсын хяналтад байдаг байна. Бага тунгаар хэрэглэх нь амьсгалын дутагдал, хүчтэй тайвшруулах, донтох зэрэг гаж нөлөө үзүүлэх ба хэтрүүлэн хэрэглэх нь үхэлд хүргэж болзошгүй.

Энэхүү хуурамч бүтээгдэхүүнийг хэрхэн таних вэ?

Энэ бүтээгдэхүүний гарал үүсэл, найрлага, эх сурвалжийг санаатайгаар буруу мэдээлсэн тул хуурамч бүтээгдэхүүн гэж тогтоосон. Уг бүтээгдэхүүнийг AUROLIFE PHARMA ХХК-ийн зах зээлд гаргадаг Оксиморфоны гидрохлоридыг дуурайлган хийсэн бөгөөд тус компани үйлдвэрлээгүй болохыг баталсан.

Энэхүү хуурамч бүтээгдэхүүнийг танихын тулд дараах байдлаар шалгана.

- Хуурамч хувилбарын анхдагч савлагааны хаяг дээр бар код байхгүй.
- Хуурамч хувилбарын савлагаан дээр 40мг гэж бичигдсэн. AUROLIFE PHARMA үйлдвэрлэгчийн Оксиморфоны гидрохлорид нь зөвхөн 5мг ба 10мг тунтай байна.
- Шахмалын хуурамч хувилбаруудад товойсон үсэг/тоо байхгүй.
- Хуурамч бүтээгдэхүүний шошгон дээр АНУ-ын үндэсний эмийн код байхгүй.

Эрсдэл

Энэхүү хуурамч бүтээгдэхүүн нь АНУ-ын Эм, Хүнсний агентлагаас зөвшөөрөгдсөн AUROLIFE PHARMA ХХК-ны Оксиморфоны гидрохлорид эмийг дуурайх зорилгоор санаатайгаар зохион бүтээгдсэн байж болзошгүй. Түүнд агуулагдах метонитазен нь бага тунгаар ч гэсэн сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөр тул хэрэглэгчдэд эрсдэл ихтэй. Метонитазен нь бусад опийн бүлэгтэй төстэй нөлөө үзүүлдэг, их тунгаар хэрэглэх нь үхэлд хүргэх эрсдэлтэй.

Энэхүү хуурамч бүтээгдэхүүнийг хэрэглэх нь амь насанд аюул учруулж болзошгүй.

Эмнэлгийн мэргэжилтнүүд, Эмийн зохицуулалтын байгууллагууд, олон нийтэд өгөх зөвлөгөө

Эмнэлгийн мэргэжилтнүүд аливаа гаж нөлөө, эмчилгээ үр дүн муутай байх, хуурамч хэмээн сэжиглэсэн тохиолдлын талаар Эмийн зохицуулалтын байгууллагад мэдээлэх, эдгээр хуурамч бүтээгдэхүүнд өртөж болзошгүй улс орон, бүс нутгуудын нийлүүлэлтийн сүлжээнд хяналт, шалгалтыг нэмэгдүүлэхийг, албан бус болон зохицуулалтгүй зах зээлд тавих хяналтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.

Хүснэгт 3. ДЭМБ-ын сэрэмжлүүлэг №03/2024

Бүтээгдэхүүний нэр	Oxymorphone Hydrochloride 40mg
Үйлдвэрлэгч	Aurobindo Pharma Limited, Hyderabad-500 038, India
Цувралын дугаар	H20330826
Хүчинтэй хугацаа	08/2026
Илэрсэн улс	Финланд
Илэрсэн байдал	



ЗМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



**ХҮН ТӨРӨЛХТӨН ВАКЦИН ХЭРЭГЛЭЖ
ЭХЭЛСНЭЭС ХОЙШ 20 ТӨРЛИЙН АЮУЛТ
ӨВЧНӨӨС ОЛОН САЯ ХҮНИЙ АМЬ НАСЫГ
АВАРЧ БАЙНА.**

ТАЙЛАН, СУДАЛГААНЫ АЖИЛ

2016–2022 ОНУУДАД ЭМ, БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАР СУРТАЛЧИЛГААНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

С.Сарнай¹, Э.Ундармаа², С.Мөнхбат³, Д.Нарантунгалаг¹

¹АШУҮИС, БАС, Эм судлалын тэнхим

²ЭЭХХЗГ, мэргэжилтэн

АШУҮИС, ЭЗС, Эмнэлзүйн эмзүй, менежментийн тэнхим

sarnai.s@mnums.edu.mn

Товч утга

Үндэслэл: Иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг дутмагаас аливаа эмийг дур мэдэн хэрэглэснээр эмийн гаж нөлөө илрэх, эмэнд дасах, хордох тохиолдол элбэгшиж, эрүүл мэнд, амь насаараа хохирох, эмчилгээний үр нөлөө буурах, эмийн харшил, бактерийн халдварын хүндрэл үүсэх зэрэг үзэгдэл ихсэж байгаа нь эмч мэргэжилтнүүдийг түгшээж байна. Эмийн зохистой хэрэглээг алдагдуулж байгаа олон шалтгааны нэг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарим эмийг хэт дөвийлгөх, илэрч болох гаж нөлөөг орхигдуулж, өрөөсгөл байдлаар сурталчлах буюу төөрөгдүүлсэн зар сурталчилгаа ихсэх хандлагатай байгаа тул уг судалгааг хийж гүйцэтгэв.

Зорилго: Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, хэрэглэгчдийг төөрөгдүүлэх, үнэн бодит бус мэдээллээр хангахаас сэргийлэх зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаанд үнэлгээ хийх.

Арга аргачлал: Судалгааг 2016-2022 оны хооронд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох телевизээр түгээж байгаа жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны мэдээллийг цуглуулав. Дескриптив судалгааны нэг агшингийн загвараар телевизээр түгээгдсэн эм болон биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны агуулгын хүрээнд мэдээллийг түгээгдсэн эсэх, Эм судлалын салбар зөвлөлийн зөвшөөрөл олгогдсон байдал зэргийг тодорхойлон үр дүнг боловсруулав.

Үр дүн: 2016-2022 оны хооронд нийтдээ 591 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн буюу жилд дунджаар 64-89 нэрийн жоргүй олгодог эмэнд эмийн зар сурталчилгааны зөвшөөрөл олгогдсон байна. Зөвхөн 2022 онд 81 нэрийн эм, 43 нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүн, нийт 124 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнд олгосон байна. Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг Live TV телевиз хамгийн бага буюу 22 секунд, өөрөөр хэлбэл 2 удаагийн давтамжтайгаар эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа түгээсэн байна. Хуулийн заалт зөрчсөн тохиолдол нийт түгээсэн зар сурталчилгаанд 24 буюу 4.06% байв.

Дүгнэлт: Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг 17 өргөн нэвтрүүлэг, арилжааны телевизээр түгээсэн байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн 432 нэрийн эм, 159 нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа буюу 64.4% нь зөвшөөрөл авсан байна. 326 (35,6%) нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа зөвшөөрөл аваагүй түгээсэн буюу олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /телевиз/-ээр дамжин иргэдэд хүрч буй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа нь холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцэж байгаа ч хангалтгүй хэмээн дүгнэв.

Түлхүүр үг: олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, агуулгын дүн шинжилгээ, жоргүй олгогддог эм, хуулийн заалт

Үндэслэл:

Манай улсад эм хангамжийн байгууллага хувийн хэвшилд бүрэн шилжсэнээс хойших эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний олон нийтийн хэрэгслээр түгээгдэж буй зар сурталчилгааны талаарх судалгаа, мэдээ баримт дутагдалтай байна.¹ Эмийн зохистой хэрэглээ гэдэг нь тухайн хүний нас, биеийн онцлог, өвчний байдалд тохирсон эмийг эмчийн заавраар зөв сонгон, зохих тунгаар, тодорхой хугацааны турш хэрэглэхийг хэлдэг.² Эмийн зохистой хэрэглээний хүрээнд эмийг зөв сонгох, тун хэмжээ, эмчилгээний үргэлжлэх хугацааг нарийн тогтоох, хэрэглэх эмүүд өөр хоорондоо тохиромжтой байх, хоол ундны дэглэмийг эмийн хэрэглээтэй уялдуулах, эмчилгээний үр дүнг хянах зэрэг олон асуудал багтдаг. Жоргүй олгогддог эмийг зөв, зохистой хэрэглэхэд зар сурталчилгаа сайн, муу хоёр талаар нөлөөлж буйг судлаачид онцолж байна.³ Эм, бэлдмэлийн зар сурталчилгааг дотор нь олон ангилалд хуваан авч үздэг. Одоогоор хэд хэдэн төрлийн эмийн сурталчилгаа байдаг. Нэг төрөл нь «тусламж эрж буй сурталчилгаа», энэ нь зөвхөн эрүүл мэндийн байдлын талаар мэдээлэл өгдөг бөгөөд эмчлүүлэгчдийг эмчтэйгээ холбоо барихыг дэмждэг ч ямар нэг бүтээгдэхүүний талаар дурддаггүй. Өөр нэг ангилал нь бүтээгдэхүүний нэрийг агуулсан “сануулах сурталчилгаа” юм. Энэ төрөл нь эмийн хүч, тунгийн хэлбэр, үнийн талаар мэдээлэл өгч болох боловч заалтыг дурдахгүй. Гурав буюу хамгийн түгээмэл төрөл нь бүтээгдэхүүн, түүний талаар дурдсан «бүтээгдэхүүний зар сурталчилгаа» юм. Үүнд хэрэглэх заалт, үр дүн, аюулгүй байдлын талаарх мэдээллийг агуулдаг. Зар сурталчилгааны ангилал бүр Америкийн Нэгдсэн Улсын (АНУ) Хүнс, эмийн агентлагын зохицуулалтад (FDA) өөр өөр хязгаарлалттай байдаг. Эмийн зар сурталчилгааг түгээхэд ашигладаг сувгуудад ихэвчлэн телевиз, хэвлэл (сэтгүүл, сонин, тараах материал), радио, интернет болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (сурталчилгааны самбар, шуудан) орно.⁴ Орчин үед эмийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж, эмийн нэр, төрөл олширч байгаа нь эмийг зөв сонгох, оновчтой хэрэглэхэд улам бүр төвөгтэй байдлыг бий болгож байгаа бөгөөд эмч, эм зүйч төдийгүй иргэдэд ч үнэн зөв мэдээлэл чухал хүргэх шаардлага гарч байна. Монгол улсад 2002 онд батлагдсан 68 дугаар тогтоолд “Эмийн талаар төрөөс баримтлах бодлогод эмийн сурталчилгааг холбогдох хууль тогтоомж болон олон улсын хэмжээнд баримталдаг ёс зүйн хэм хэмжээний хүрээнд явуулах нөхцөл бүрдүүлнэ” гэж заасны дагуу эмийн зар сурталчилгааны зохицуулалт хийж эхэлсэн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 27 дугаар зүйлд “Жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг мэргэжлийн болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж болно” гэж заасан.⁵ Мөн зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлд “Олон нийтийн мэдээлэх хэрэгслээр зөвхөн жоргүй олгох эмийн тухай болон эмийг зохистой хэрэглэхтэй холбогдсон сурталчилгаа явуулж болно” гэж заасан.⁶ Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сурталчлах зөвшөөрлийг зөвхөн улсын бүртгэлд бүртгэгдсэн бүтээгдэхүүнд Эм судлалын салбар зөвлөлийн шийдвэрийн дагуу агуулгыг нь баталгаажуулан олгож байна. Иймээс одоогоор эм түүнчлэн биологийн идэвхт бүтээгдэхүүний олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээж байгаа зар сурталчилгааны талаар хийсэн судалгаа хомс байгаа нь судалгаа хийх үндэслэл болж байна.

Зорилго:

Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, хэрэглэгчдийг төөрөгдүүлсэн, бодит бус мэдээллээр хангахаас сэргийлэх зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу телевизээр түгээж буй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаанд үнэлгээ хийх зорилго тавив.


Арга, аргачлал:

Судалгааг 2016-2022 онуудад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, телевизээр түгээж байгаа жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны мэдээллийг нэг агшингийн загвараар телевизээр түгээгдсэн эм болон биологийн идэвхт бүтээгдэхүүний

зар сурталчилгааны мэдээллийг “Максима медиа” ХХК-ны санд буй 2016-2022 онуудад жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний мэдээлэл, Эм судлалын салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр зөвшөөрөл олгосон эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны мэдээлэл, Монгол Улсын эмийн бүртгэлийн цахим систем www.licemed.gov.mn мэдээллийн баазыг ашиглан хяналт, шинжилгээ хийв.


Үр дүн:

Судалгаагаар 2016-2022 онуудад нийт 591 нэрийн эмийн зар сурталчилгааны зөвшөөрөл олгогдсон ба жилд дунджаар 76.5 нэрийн жоргүй олгодог эмэнд эмийн зар сурталчилгааны зөвшөөрөл олгожээ. 2016 оноос эхлэн Эм судлалын салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр 37 эм, 23 нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүнд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл буюу телевизээр зар сурталчилгаа хийх зөвшөөрлийг олгож эхлэн, жил ирэх тусам нэмэгдсээр 2022 онд 81 эм, 43 нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгосон нь өмнөх жилүүдтэй харьцуулахад дундаж үзүүлэлттэй байна. Үүнтэй зэрэгцэн зөвшөөрөлгүйгээр эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг түгээсээр байна. Дээрх 7 жилийн хугацаанд нийт 326 эм, биологийн идэвхт бодисын зар сурталчилгаа зөвшөөрөлгүй цацагджээ (Зураг 1).



Зураг 1. Зөвшөөрөлтэй түгээгдсэн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа, зөвшөөрөлгүй түгээгдсэн зар сурталчилгааны тоо.

Үүний зэрэгцээ зар сурталчилгааны 175 агуулга холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, хүч нэмэгдүүлсэн үг хэллэгтэй, хүүхдэд чиглэсэн (бага насны хүүхдэд чиглэсэн, оролцуулсан сурталчилгааг хориглодог) зэрэг шалтгааны улмаас зөвшөөрөл олгох боломжгүй гэсэн шийдвэр гаргажээ (Зураг 2).



Зураг 2. Зар сурталчилгааны зөвшөөрөл олгогдоогүй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний тоо

Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг 2022 онд 17 өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизээр түгээснээс ТВ9 телевиз хамгийн их буюу 64934 секундын 5948 удаагийн давтамжтай, ТВ25 телевиз 29781 секунд буюу 1973 удаагийн давтамжтай түгээжээ. Live TV телевиз хамгийн бага буюу 22 секунд 2 удаагийн давтамжтай эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа түгээсэн байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Телевизүүдийн зар сурталчилгаа түгээж буй хугацаа, давтамж

	секунд	давтамж	Үйл ажиллагаа явуулж буй хугацаа /жил/
ТВ9	64934	5948	21
ТВ25	29781	1973	28
Live tv	22	2	4

Мөн зар сурталчилгаа түгээх зөвшөөрөл авсан хэдий ч нийт түгээсэн зар сурталчилгааны 24 (4,06%) нь агуулгын хувьд хуулийн заалт зөрчсөн байна. Тухайн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн нь улсын бүртгэлээс хасагдсан, өндөр тунтай байхаас гадна сөрөг нөлөөгүй, чанартай, дэлхийд номер нэг, бүрэн эдгээнэ, шидэт бэлдмэл гэх мэт хүч нэмсэн үг хэллэг хэрэглэж хуулийн холбогдох заалтыг зөрчсөн агуулгатай, мөн зар сурталчилгааны зөвшөөрөл авахдаа хянуулсан үг хэллэгт хүч нэмэгдүүлсэн үг хэллэг нэмж зар сурталчилгааг түгээсэн тохиодол илэрсэн.

Хэлцэмж:

Монгол улсад Эрүүл Мэндийн Яамны Хүний эмийн зөвлөлийн Эм судлалын салбар зөвлөлөөр зөвхөн улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны агуулгыг хянаж, баталгаажуулж, зөвшөөрөл олгодог. АНУ-д Холбооны Худалдааны Комисс (FTC) нь жоргүй олгодог эмийн зар сурталчилгааг зохицуулах үүрэгтэй байгаа нь төстэй байна.⁷ Мөн эмийг ховор, чухал, цорын ганц, маш өндөр идэвхтэй, үр дүн нь бусад эмээс илүү, аюулгүй, гаж нөлөөгүй, шинэ эм, бүрэн эдгээнэ, патентлагдсан гэж хэрэглэгчийг төөрөгдүүлэх заалтууд оруулдагаараа ижил байна.⁵ Адриенне Е нарын судалгаанд 2008–2010 оны хооронд жортой, жоргүй олгогддог эмийн 15,925 зар

сурталчилгааны агуулгыг үнэлэхэд телевизийн сурталчилгааны ихэнх нь буюу 57% нь төөрөгдүүлсэн, 10% нь худал агуулгатай байгааг дүгнэсэн бол бидний судалгаанд 4.06% нь төөрөгдүүлсэн агуулгатай байв.⁸ Хелен нарын судалгаанд олон зар сурталчилгаа нь эрсдэлгүй мэдээллийг дамжуулахын тулд үндсэн мэдэгдлийн үеэр давхардсан текстийг ашигласан нь иргэдийг төөрөгдүүлж буйг мөн дурджээ.⁹

Эмийн зар сурталчилгаатай холбоотой бусад судалгаанд тухайлбал Эрика Д нарын судалгаанд 2001 оны зуны саруудад жортой, жоргүй олгогддог 18,906 зар сурталчилгаанд үнэлгээ хийхэд ихэвчлэн ахимаг настай эмэгтэйчүүд зонхилон үзэж, зар сурталчилгаа цацагдаж байгаа оргил цаг нь мэдээ, олон ангит кинон дундуур байна гэж дүгнэжээ.¹⁰ Бидний судалгаанд уг судалгаатай ижил ямар хүйсний хүмүүс, аль цагаар эмийн сурталчилгаа үзэж буйг тогтоох боломж байгаагүй нь судалгааны хязгаарлагдмал тал болж байна. Ихэнх улс оронд жортой, жоргүй олгох эмийг сурталчлахыг зөвшөөрдөгөөсжоргүй олгох эмийн сурталчилгаа ихэнх хувийг эзэлж байгаа нь Паулин Норрис нарын судалгаанаас харагдаж байна, харин Монголд хуулийн заалтаараа зөвхөн жоргүй олгогддог эмийн сурталчилгааг зөвшөөрдөг нь судалгааны бас нэгэн сул тал боллоо.¹¹

Ковид 19 цар тахлын үед эмийн зар сурталчилгааны тоо өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй өсөлттэй байсан буюу 2020 онд 59, 2021 онд 93 болж өссөн нь Давид Бланко Херреро нарын судалгаанд эрүүл мэндийн зар сурталчилгааны хамгийн бага хувь нь хөл хорионы үеэр байсан бол хөл хориог цуцалж эхэлмэгц ихэссэн гэж дүгнэсэнтэй төстэй байв.¹² Мөн Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй MAXIMA MEDIA - пиплметр технологиор Улаанбаатар хотын хэмжээнд Телевиз үзэлтийн судалгааг хийж буй мэргэжлийн судалгааны компанийн 2020 оны Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайланд уг онд хамгийн их зар сурталчилгаа цацсан бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлүүд дотор эмийн бүтээгдэхүүний зар сурталчилгаа III байранд жагсах хүртэл хүч түрэн орж ирсэн буюу нэг жилийн дотор 2,714,268 секундын сурталчилгаа цацагдсанг дурджээ.¹³

Дүгнэлт:

Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг 17 өргөн нэвтрүүлэг, арилжааны телевизээр түгээсэн байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн 432 нэрийн эм, 159 нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа буюу 64.4% нь зөвшөөрөл авсан байна. 326 (35,6%) нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа зөвшөөрөл аваагүй түгээсэн буюу олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /телевиз/-ээр дамжин иргэдэд хүрч буй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа нь холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцэж байгаа ч хангалтгүй хэмээн дүгнэв.

Зөвлөмж:

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /телевиз/-ээр дамжин иргэдэд хүрч буй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа нь холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцэж байгаа ч хангалтгүй байгаа нь цаашид хяналт, зохицуулалтыг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Номзүй:

1. Энхтуул Б. Монгол улсын эмийн зах зээл дэх зарим эмийн чанарын үнэлгээний судалгаа. Магистрын нэг сэдэвт бүтээл. Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль. 2013. Х:3-4.
2. Mamo DB, Alemu BK. Rational Drug-Use Evaluation Based on World Health Organization Core Drug-Use Indicators in a Tertiary Referral Hospital, Northeast Ethiopia: A Cross-Sectional Study. Drug, Healthcare and Patient Safety. 2020;12 15–21 doi:10.2147/DHPS.S237021
3. Frank Auton. The case for advertising pharmaceuticals direct to consumers. Future Medicinal Chemistry. Volume 1, Issue 4, July 2009, Pages 587-592. doi:10.4155/fmc.09.58
4. C. Lee Ventola. Direct-to-Consumer Pharmaceutical Advertising Therapeutic or Toxic? P T. 2011 Oct; 36(10): 669-674, 681-684.
5. <https://legalinfo.mn/mn/detail/85>
6. <https://legalinfo.mn/mn/detail/259>
7. <https://www.usa.gov/agencies/federal-trade-commission>
8. Adrienne E. Content Analysis of False and Misleading Claims in Television Advertising for Prescription and Nonprescription Drugs. J Gen Intern Med 29(1):110–8 doi: 10.1007/s11606-013-2604-0.
9. Helen W. Sullivan. Communicating Risk Information in Direct-to-Consumer Prescription Drug Television Ads: A Content Analysis. Health Commun. 2019 Feb;34(2):212-219. doi: 10.1080/10410236.2017.1399509.
10. Erica D Brownfield. Direct-to-consumer drug advertisements on network television: an exploration of quantity, frequency, and placement. J Health Commun. 2004; 9(6):491-7. doi: 10.1080/10810730490523115.
11. Pauline Norris. Advertising of medicines on New Zealand television. N Z Med J. 2005 May 20;118(1215):U1462.
12. HDavid Blanco-Herrero. ealth Advertising during the Lockdown: A Comparative Analysis of Commercial TV in Spain. Int. J. Environ. Res. Public Health 2021, 18, 1054. doi. org/10.3390/ijerph18031054.
13. <https://maxima.mn/2020-tam-tailan>



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



**ВАКЦИН ХИЙЛГЭСНИЙ ДАРАА ХӨНГӨН
ХЭЛБЭРИЙН УРВАЛ ИЛЭРЧ БОЛНО**

ASSESSMENT FOR ADVERTISING OF MEDICINES AND BIOLOGICALLY ACTIVE PRODUCTS IN 2016-2022

¹Sarnai S, ²Undarmaa E, ³Munkhbat S, ¹Narantungalag D

¹Department of Pharmacology, School of Biomedicine, MNUMS

²DMD CRA, officer

³Department of Clinical Pharmacy and Management, School of Pharmacy, MNUMS

Background:

Medical professionals worry that due to arbitrary use of drugs, side effects of drugs, addiction to drugs, poisoning cases are increasing, health and life loss, reduction of treatment effectiveness, drug allergy, and bacterial infection complications are increasing because of lack of knowledge about the rational use of drugs among people. The study was conducted because one of the many reasons for undermining the rational use of medication is that the media ignores and biases the side effects of certain medications.

Aim:

To evaluate medicine and biologically active product advertisements broadcasted on social media in order to educate citizens about the rational use of medicines and to prevent consumers from being provided with misleading and false information.

Materials and Methods:

The study collected data on TV-distributed advertising data of over-the-counter drugs and biological active products between 2016 and 2022. Using a descriptive study's cross-section design, results were developed to determine whether the information was broadcasted within the content of advertisements for medicines and bioactive products and the status of the approval of the Pharmacological branch committee.

Results:

Between 2016 and 2022, a total of 591 medicines advertising permissions were approved. On average, 64-89 over-the-counter drugs are approved for drug advertising per year. Only in 2022, 81 branded medicines and 43 branded biologically active products were granted and a total it was 124. The minimum Live TV broadcast was 22 seconds or 2 times for medicine and biologically active products. Violation of legal provisions was 24 or 52% of all distributed advertisements.

Conclusions:

Advertisements for medicines and biologically active products were distributed on 17 broadcast and commercial television channels. 64,4% of 432 advertisements of medicines and 159 biologically active products distributed through social media (television) were approved. 326 (35,6%) medicines and biologically active products were distributed without permission and it was concluded that the advertisements of medicines and biologically active products reaching the citizens through social media/television/ are in line with the relevant legal requirements, but they are not sufficient.

Keywords:

Social media, content analysis, over-the-counter drug, legal provision

ЭМНЭЛГИЙН НЭГ УДААГИЙН БЭЭЛИЙ ХЭРЭГЛЭГЧДИЙН ТАНДАЛТ СУДАЛГАА-2023 ОН

*Ц.Өнөржаргал АУ-магистр, Тэргүүлэх зэрэгтэй ЭЭХХЗГ-ын
/Биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлын
асуудал хариуцсан мэргэжилтэн/*

Үндэслэл:

Олон улсад эмчилгээ, оношилгоонд хэрэглэж буй эмнэлгийн хэрэгслийн хэрэглэх зориулалт, хүний бие махбодод үзүүлэх эрсдэлийн түвшинг тогтоож, тэдгээрийн чанар, аюулгүй байдалд тавих шаардлага, хяналт, бодлого чиглэлийг нарийвчлан тогтоодог. Эмнэлгийн бээлий нь эмнэлгийн ажилбар, үзлэгийн үеэр өвчин үүсгэж болзошгүй халдвар, бичил биетний тархалтаас өмсөж буй хүнийг болон өвчтөнийг хамгаалахад ашигладаг хувийн хамгаалалтын хэрэгсэл юм.

Эмнэлгийн бээлий нь нэг удаагийн хэрэглээтэй бөгөөд үзлэгийн бээлий, мэс заслын бээлий багтдаг. Эмнэлгийн бээлий нь эрсдэлийн зэргээр I зэрэглэлийн эмнэлгийн хэрэгсэл гэж олон улсын хэмжээнд Хүнс, эмийн агентлаг (FDA)-аар зохицуулагддаг ба бээлийний үл нэвтрэх чанар, тодорхой физик шинж чанар, био нийцтэй байдал зэрэг шалгуурыг хангасан эсэхийг үнэлдэг байна.

Монгол улсад импортоор орж ирсэн эмнэлгийн хэрэгслийн 1.2 хувийг эмнэлгийн бээлий эзэлдэг, эдгээрийн 39.8 хувийг БНХАУ, 38.1 хувийг Малайз улсаас харин 65.8 хувь нь Чингис хаан нисэх буудлын боомтоор, 29.6 хувь нь Замын үдийн боомтоор тус тус импортолсон байна.

2023 онд эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн ажилчдын дунд эмнэлгийн бээлийний хэрэглээний талаарх тандалт судалгааг асуумж хэлбэрээр тандаж, үр дүнг дараах байдлаар дүгнэн гаргав.

Зорилго:

Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний өдөр тутмын үйл ажиллагааны хамгаалах хэрэгсэл болох резинэн бээлийний чанар, хэрэглээг тандах

Арга хэрэгсэл:

Асуумж судалгааг google forms загварыг ашиглан 4 бүлэг, 33 асуумж боловсруулан 21 аймаг, нийслэлийн ЭМГ-т ЭЭХХЗГ-ын албан тоотыг хүргүүлэн асуумжийн холбоос, QR кодыг илгээн хариултыг нэгтгэн үр дүнг SPSS statistics программ ашиглан тооцоолол хийв.

Үр дүн:

Асуумж судалгаанд нийт 725 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан, 57.3 хувь нь сум тосгоноос, 39.5 хувь нь аймаг, 3.2 хувь УБ хотоос хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан эмнэлгийн ажилчдын 37.8 хувь нь 21-30 нас, 36.4 хувь нь 31-40, 17.6 хувь нь 41-50 насны ажилчид хамрагдсан байна. Хүйсийн хувьд 90.5 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажил мэргэжлийн хувьд 37.5 хувь нь сувилагч, 29 хувь нь эмч, 9 хувь нь эх баригч бага эмч хамрагдсан байна. Зураг-1.


Эмнэлгийн бээлийний хүрэлцээ, хангалт, хэрэглээг үнэлэх асуултад 36.4 хувь нь эмнэлгийн бээлийн үргэлж хангалттай олддог, 35 хувь нь ихэнхдээ, 25 хувь нь хааяа дутагддаг, 3.3 хувь нь үргэлж дутагддаг, 0.3 хувь нь огт олддоггүй гэж хариулсан байна. 89.7 хувь нь үзлэгийн бээлий, 2.2 хувь нь мэс заслын бээлий тогтмол хэрэглэдэг байна. Та ажлын байранд өдрийн хэдэн цагт тасралтгүй эмнэлгийн бээлий хэрэглэдэг вэ? гэсэн

асуултад 1 цагаас бага гэж 30.2 хувь нь, 4 цаг гэж 15.4 хувь нь, 6-8 цаг 19.5 хувь нь хариулсан байна.

Та ихэвчлэн ямар тохиолдолд эмнэлгийн бээлий өмсдөг вэ? гэсэн асуултад 50.3 хувь нь үйлчлүүлэгчтэй харилцах бүртээ, 33.2 хувь нь халдварын сэжигтэй үед, харин 4 хувь нь бусдын шаардлагаар өмсдөг гэж хариулжээ. Эмнэлгийн ажилчдын 66.3 хувь нь талькгүй бээлий өмсдөг бол 61.9 хувь нь талькгүй бээлий өмсөх нь тохиромжтой гэж хариулсан байна.

Хэрэглэгчийн зүгээс бээлийний чанарт өгөх үнэлгээг тодорхойлох зорилготой асуумж судалгаанд оролцсон 725 эмнэлгийн мэргэжилтний 5.4 хувь нь маш сайн, 43 хувь нь сайн, 45.4 хувь нь дунд зэрэг, 5.2 хувь нь тааруу, 1 хувь нь муу гэсэн үнэлгээг өгсөн байна. Бээлий өмссөн үед хийж буй үйлдэлд ямар нэг бэрхшээл гардаг эсэхийг тодруулахад 45.1 хувь нь хааяа, 18.1 хувь нь тийм, 36.8 хувь нь үгүй гэж хариулсан байна.

Эмнэлгийн бээлий хэрэглэхтэй холбоотой ямар бэрхшээл ихэвчлэн гардаг эсэхийг тодруулахад огт үгүй гэж 17.2 хувь нь хариулсан байна. Бэрхшээл гардаг гэж хариулсан мэргэжилтнүүдийн 31.9 хувь нь амархан гэмтэж урагддаг, 30.7 хувь нь өмсгөл томддог, 11.6 хувь нь харшил өгдөг, 11.5 хувь нь өмсгөл багаддаг гэж хариулсан байна. Зураг-2.



Зураг-2. Бээлий хэрэглэхтэй холбоотой гардаг бэрхшээлүүд


Бээлий хэрэглэсэнтэй холбоотой гарын арьсанд харшил өгөх, хуурайшилт өгөх зэрэг зовуурь 37.7 хувьд нь тогтмол, 43.7 хувьд нь хааяа, 18.6 хувьд нь огт илэрдэггүй гэж хариулсан байна

Таны өмсөж буй бээлий савлагааныхаа гаднах хэмжээтэй таарч буй эсэхийг тохируулж үзнэ үү гэсэн асуултад өргөн нь тохироогүй хувь 29.8, урт нь тохироогүй хувь 20.1 хувь байна. Зураг-3.

Эмнэлгийн мэргэжилтнүүдийн бээлий өмсөхтэй холбоотой дадлыг үнэлж үзэхэд

хамгаалалтын бээлий өмсөхөөс өмнө та гараа халдваргүйжүүлдэг эсэх гэсэн асуултад 67.3 хувь тийм гэсэн бол хааяа гэж 18.6, үгүй гэж 8.7 хувь нь хариулсан байна. Бээлий тайлсны дараа гараа халдваргүйжүүлдэг болон савандаж угаадаг эсэх гэсэн асуултад 84 хувь тийм, 3.2 хувь нь үгүй гэж хариулжээ.

Ажлын орчинд гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай бодис хангалттай байдаг эсэхийг тодруулахад 90.1 хувь нь байдаг гэж хариулсан байна. Нэг эмнэлгийн бээлий өмсөөд хэдэн хүнд үйлчилдэг болохыг тодруулахад 58.3 хувь 1 гэсэн бол 41.7 хувь нь 2 ба түүнээс олон хүнд үйлчилдэг байна.



Зураг-3. Бээлийний хэмжээ шошготойгоо таарч буй эсэх

Ажлын байрнаасаа халдвар авч байсан тохиолдол 8.1 хувь, бээлий хэрэглээгүйн улмаас үүссэн архаг хууч өвчтэй хүн 6.8 хувь нь байна. Эмнэлгийн дотоод халдварын гинжин хэлхээг таслахад бээлийний хэрэглээ чухал гэсэн асуултад 19.8 хувь нь эргэлзэж, мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Бээлий өмсөөгүй үед эмнэлгийн дотоод халдвар нэмэгдэнэ гэдэгтэй та санал нийлж байна уу? гэхэд 10.3 хувь үгүй, мэдэхгүй гэж хариулсан байна.

Санал хүсэлт:

Ач холбогдол бүхий 58 санал ирснээс хамгийн олон буюу 30 ажилчин бээлийний чанарыг сайжруулах (нимгэн, үнэргүй, талькгүй, бат бөх, урагддаггүй, харшил өгдөггүй байх), 19 хувь нь хангалтыг сайжруулах, бусад саналд үнийг бууруулах, дотооддоо хангалттай үйлдвэрлэх, эмч ажилчдад сардаа 1 удаа сургалт хийдэг байх, тендерт үнийн доод хэмжээг биш чанарын үзүүлэлтийг чухалчлах, бээлийний хог хаягдлыг багасгах зэрэг саналуудыг гаргасан байна.

Дүгнэлт:

Эмнэлгийн бээлийний дутагдал эмнэлгийн ажилчдын 4 хүн тутмын 1-нь өртөж байна. 10 ажилчин тутмын 5 нь ажлын 8 цагийн 3 ба түүнээс дээш цагт нь байнгын эмнэлгийн бээлий өмсөн ажиллаж байна.

ЭМБ-ын хэмжээнд 66.3 хувьд нь талькгүй бээлий хэрэглэж байна. Эмч, эмнэлгийн ажилчдын 50 орчим хувь нь эмнэлгийн бээлийний чанарт эргэлзэж байна. Тэдний хэрэглэж буй бээлий амархан урагддаг, хэврэг, өмсгөл таардаггүй, бээлийний хангалт хүрэлцээгүй байхаас гадна харшил өгч, гар хуурайшуулах зовуурь өгдөг гэсэн байна.

2 ажилчин тутмын 1 нь үйлчлүүлэгчтэй харилцах бүртээ бээлий өмсдөг байна. Бээлий өмсөхөөс өмнө болон бээлий тайлсны дараа 5 хүн тутмын 1 нь гараа халдваргүйжүүлдэггүй, 40 орчим хувь нь 1 бээлийгээр 2 ба түүнээс дээш үйлчлүүлэгчтэй харьцдаг байна.

Ном зүй:

1. Preece, D., Lewis, R. orcid.org/0000-0002-4300-0540 and Carre, M.J. (2021) A critical review of the assessment of medical gloves. Tribology: Materials, Surfaces and Interfaces, 15 (1). pp. 10-19. ISSN 1751-5831
2. Daniel B. Kramer^{1,2*}, Yongtian T. Tan¹, Chiaki Sato³, Aaron S. Kesselheim^{1,4}. Postmarket Surveillance of Medical Devices: A Comparison of Strategies in the US, EU, Japan, and China. PLOS Medicine | www.plosmedicine.org 1 September 2013 | Volume 10 | Issue 9 | e1001519.
3. Part 4: Requirements and testing for shelf life determination .Medical gloves for single use. Standard - Medical gloves for single use - Part 4: Requirements and testing for shelf life determination SS-EN 455-4:2009 - Swedish Institute for Standards, SIS

ЭМИЙН ЭМЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2023 ОНЫ ТАЙЛАН

У.Соёл-Эрдэнэ ЭЭХХЗГ-ын
/Эмийн зохистой хэрэглээний асуудал
хариуцсан мэргэжилтэн/


Ерөнхий хэсэг

ЭМС-ын 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/414 тоот тушаалаар баталсан “Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам”-ын дагуу тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, 40-с дээш ор бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүд хорооны үйл ажиллагааны тайланг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор бичгээр болон цахимаар 4 хавсралтын дагуу тайлагнадаг.


Журмын дагуу дээрх эрүүл мэндийн байгууллагууд шатлалаас хамааран 5-9 гишүүдийн бүрэлдэхүүнтэй эмийн эмчилгээг зохицуулах хороо түүн дотроо антибиотикийн дэд хороог байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Энэхүү тайланд тухайн жилд эрүүл мэндийн байгууллагуудын эмийн хэрэглээний талаарх мэдээлэл, антибиотикийн эмийн хэрэглээний талаарх мэдээ, антибиотик мэдрэг чанар тодорхойлох дүн, бичмэл тайланд (эмийн гаж нөлөө, чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмж, эмийн зохистой хэрэглээ) чиглэлээр хийсэн ажлуудын мэдээлэл багтдаг.


ЭЭХХЗГ-т Эмийн эмчилгээг зохицуулах хорооны тайланг 2023 оны байдлаар нийт 87 эрүүл мэндийн байгууллага тайлагнаж ирүүлэхээс 61 (70.1%) тайлагнасан. Үүнээс гүйцэд тайлагнасан нь 39 (63.9%) байна. Өмнөх оны тайлантай харьцуулахад тайлан ирүүлсэн эрүүл мэндийн байгууллага 4,6% аар илүү байна. Тайланг 22 (36.1%) дутуу, алдаатай ирүүлсэн бол 26 байгууллага ирүүлээгүй байна. /Зураг 1, 2, 3, 4/




Зураг 1. Тус онд тайлан ирүүлсэн байдлыг өмнөх онотой харьцуулхад



Зураг 2. Тайланг журмын дагуу тайлагнасан




Зураг 3. Тайланг алдаатай, мэдээлэл дутуу тайлагнасан



Зураг 4. Тайланг ирүүлээгүй байгууллага

Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн тайланг 4 хавсралт тус бүр үнэлэхэд хавсралт 2- эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээ 49 (80.3%), хавсралт 3-эмнэлгийн антибиотик эмийн хэрэглээний талаарх мэдээ 50 (81.9%), хавсралт 3-2 эмнэлгийн антибиотик эмийн хэрэглээ нэр төрлөөр 45 (73.7%), хавсралт 4- антибиотик мэдрэг чанар тодорхойлсон дүн 45 (73.7%) дунджаар 77.4% тайлагнасан байна. /Зураг 5/



Зураг 5. Тайланг нийт 5 хавсралтаар ирүүлсэн байдал


Эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээ (хавсралт 2)

Эрүүл мэндийн байгууллагуудад нийт 2023 оны байдлаар 599.964 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн байна. Өмнөх он буюу 2022 оны тайлантай харьцуулахад 108.176 эмчлүүлэгчээр их бол 2021 оныхтой харьцуулахад 224.549 эмчлүүлэгчээр бага хэвтэн эмчлүүлсэн байна. /Зураг 11/




Зураг 11. Эрүүл мэндийн байгууллагуудад нийт хэвтэн эмчлүүлсэн эмчлүүлэгчийн тоо

Нийт эрүүл мэндийн байгууллагуудад дундаж ор хоног болон эмчилгээнд нэг зэрэг хэрэглэсэн эмийн дундаж тоог харьцуулан үзэхэд 1 хэвтэн эмчлүүлэгчид 7 хоногт 7.2 нэр төрлийн эм хэрэглэж үйлчилсэн бол өмнөх оны тайлантай харьцуулахад эмчилгээнд нэгэн зэрэг хэрэглэсэн эмийн дундаж 0.7% их байна. /Зураг 12/.



Зураг 12. Дундаж ор хоног, Эмийн дундаж тоо

Нийт эмчилгээнд дунджаар антибиотик эмийн эзлэх хувь 22.3%, тарилгын эм 53.5%-ийг тус тус эзэлж байна. Өмнөх оны тайлантай харьцуулахад антибиотик эмийн эзлэх хувь 1.9% их, тарилгын эмийн эзлэх хувь 7,1% их хэрэглэсэн байна. /Зураг 13/.



Зураг 13. Эмчилгээнд антибиотик эмийн эзлэх хувь, тарилгын эм, хувиар


Бичмэл тайлан (хавсралт 5) нийт 57 эрүүл мэндийн байгууллага (93.4%) тайлагнаснаас эмийн зохистой хэрэглээний мэдээлэл, сургалт сурталчилгаа, эмийн жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт 46 (80.7%) тайлагнаж, 14 (24.5%) нь хангалтгүй ирүүлсэн байна.

Антибиотикийн дэд хорооны тайлан

Тус онд хавсралт 3 эмнэлгийн антибиотик эмийн хэрэглээний талаарх мэдээ 50, хавсралт 3-2 антибиотик эмийн нэр төрлөөр хэрэглээний мэдээг 45, хавсралт 4- нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээг 45 эрүүл мэндийн байгууллага тус тус тайлагнасан байна. Тайланд тухайн эрүүл мэндийн байгууллага нь нянгийн эсрэг эм хэрэглэдэггүй, мэдрэг чанарын шинжилгээ хийдэггүй (сувилал гм) байгууллагуудыг оруулаагүй болно.


Антибиотикийн эмийн хэрэглээний талаарх мэдээ (хавсралт 3)

Тус онд нийт 573,425 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлж, түүний 25.1%-д нь нянгийн эсрэг эмийг эмчилгээнд хэрэглэсэн байна. Эдгээр үйлчлүүлэгчид мэдрэг чанарын шинжилгээ хийгдсэн байдлыг үнэлэхэд дунджаар 4 эмчлүүлэгч тутмын 1-д нь тус шинжилгээг хийсэн байна. /Зураг 1/.




Зураг 1. Мэдрэг чанарын шинжилгээний хамрагдалт, хувиар, тоогоор

Эмнэлэгт 2021 онд дунджаар 3 эмчлүүлэгч тутам 1 (31.1%), 2022 онд дунджаар 4 эмчлүүлэгч тутмын 1 (25.5%), 2023 онд (25.1%) тус тус мэдрэг чанарын шинжилгээ хийгдсэн байна. /Зураг 2/




Зураг 2. Нянгийн эсрэг эмийн бүлгүүдэд мэдрэг, мэдрэг бус байдал, хувиар 2021-2023 он

Эрүүл мэндийн байгууллагуудын 2022 онд эмийн эмчилгээнд хэрэглэсэн нянгийн эсрэг эм дунджаар 23.8% байсан бол 2023 онд 21.5% буюу өмнөх онтой харьцуулахад 2.3%-иар буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 3/.




Зураг 3. Эмчилгээнд хэрэглэсэн нийт нянгийн эсрэг эм, хувиар

Эмчилгээнд хэрэглэсэн нянгийн эсрэг эмийн 68% тарилга хэлбэрээр хэрэглэсэн байна./
Зураг 4/




Зураг 4. Тарилга хэлбэрээр хэрэглэсэн нянгийн эсрэг эм, хувиар

Эрүүл мэндийн байгууллагууд дунджаар 4 нэр төрлийн нянгийн эсрэг эмийг 1 хэвтэн эмчлүүлэгчид хэрэглэсэн байна /Зураг 5/




Зураг 5. Нэг үйлчлүүлэгчид хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчилгээнд хэрэглэсэн антибиотик эмийн дундаж, тоогоор

Урьдчилан сэргийлэх зорилгоор нийт эмчлүүлэгчийн 10.5%-д нянгийн эсрэг эмийн хэрэглэсэн нь /Зураг 5/-с харагдаж байна. Үүнээс төрөлжсөн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд эмчлүүлэгчийн 17.2% буюу 5 хүн тутмын 1-д урьдчилан сэргийлэх зорилгоор нянгийн эсрэг эм хэрэглэсэн байна. /Зураг 6/




Зураг 6. Урьдчилан сэргийлэх зорилгоор нянгийн эсрэг эмийн хэрэглээ, хувиар

Нянгийн эсрэг эмийг тарилга хэлбэрээс уух хэлбэрт нийт эмчлүүлэгчийн 2.94%-д шилжүүлэн хэрэглэсэн байна. /Зураг 7/



Зураг 7. Тарилгын хэлбэрээс уух хэлбэрт шилжүүлсэн эмчлүүлэгч, тоо, хувиар

Эмнэлгүүд тус журмын хавсралт 3-ын дагуу нянгийн эсрэг эмийн хэрэглээг эмийн нэр төрлөөр ирүүлсэн мэдээлэлд ДЭМБ-ын өдрийн тунлагдсан тооцооллоор /ӨТТ/ 100 ор хоногт тооцон хэрэглээг үнэлсэн. Тус онд нянгийн эсрэг эмийн хэрэглээ 2804.65 ӨТТ/100 ор хоног байна. Үүнийг эмнэлгүүдийн шатлалаар авч үзэхэд төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүд 39% буюу хамгийн өндөр хэрэглэсэн харагдаж байна. /Зураг 8/.




Зураг 8. Нянгийн эсрэг эмийн хэрэглээ ӨТТ/100 ор хоног, хувиар

Хэрэглээг ДЭМБ-ын AWARE (хүртээмжтэй байлгах, хянах, нөөцлөх) ангиллын дагуу үнэлэхэд 2022 онд эрүүл мэндийн байгууллагууд хүртээмжтэй байлгах бүлгийн хэрэглээ 47.8%, хянах бүлэг 52.1%, нөөцлөх нь 0.1% байсан бол 2023 хүртээмжтэй байлгах бүлгийн хэрэглээ 47.8%, хянах бүлэг 52.1%, нөөцлөх 0.1% -ийг тус тус эзэлж байна. Үүнээс үзэхэд хүртээмжтэй байлгах бүлгийн антибиотик 25.1%-иар буурч, хянах бүлгийн антибиотик 25,1%-иар ихэссэн байна.

Хүснэгт 2. AWARE ангиллын хэрэглээ, хувиар

AWARE ангилал	2021 он	2022 он	2023 он
Access-хүртээмжтэй байлгах	41.6%	72.9%	47.8%
Watch-хянах	58.3%	27%	52.1%
Reserve-нөөцлөх	0.1%	0.1%	0.1%

Нянгийн эсрэг эмүүдийг нэр төрлөөр хэрэглээг үнэлэхэд цефазолин 65.80%, цефотаксим 9.08%, цефтриаксон 4.10% -ийг эзэлж байна. Харин нөөцлөх бүлгийн нянгийн эсрэг эмүүдээс линезолид, колистин нарын хэрэглээ 1% хүрэхгүй байна /Зураг 9/.



Зураг 9. Нянгийн эсрэг эмийн хэрэглээ, нэр төрлөөр, хувиар

ЭМИЙН ГАЖ НӨЛӨӨ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Эмийн гаж нөлөөний үндэсний мэдээний санд 2023 оны байдлаар нийт 232 тохиолдол бүртгэгдсэний 87.5% нь 40-өөс дээш ор бүхий эмийн эмчилгээний зохицуулах хорооны тайлан ирүүлдэг эмнэлгүүдээс бүртгэгдсэн. 2023 оны байдлаар тайлан ирүүлсэн 61 эмнэлэгт нийт 141 гаж нөлөөний тохиолдол бүртгэгдсэн тухай тайланд тусгагдсаны 87 (61,7%) тохиолдол нь ЭЭХХЗГ-ийн үндэсний мэдээний санд бүртгэгдсэн байна. Эрүүл мэндийн байгууллагаар авч үзвэл төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүд нийт бүртгэгдсэн гаж нөлөөний 65,5%, тусгай мэргэшлийн төв 71,7%, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ 73,1%, хувийн хэвшлийн эмнэлэг 97% тус тус мэдээлсэн бол дундаж үзүүлэлтээр **76,8%** байна.




Зураг 2. 2023 онд эмнэлэгт бүртгэгдсэн нийт гаж нөлөөний тохиолдлыг ЭЭХХЗГ-т мэдээлсэн байдал

2023 оны байдлаар эмнэлэгт илэрсэн нийт гаж нөлөөний тохиолдлын 76,8%-ийг холбогдох журмын дагуу ЭЭХХЗГ-т бүрэн мэдээлэгдсэн дундаж үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулахад 2021 он (32,34%)-оос 44,5%-иар, 2022 он (39,74%)-оос 37,1%-иар тус тус өссөн эерэг үзүүлэлттэй байна. Зураг 2

Тайлан мэдээлсэн эмнэлэгт 77 тохиолдол буюу нийт эмэнд илэрсэн гаж нөлөөний 54,6%-ийг антибиотик эмийн гаж нөлөөний тохиолдол эзэлж байна.

Антибиотик эмэнд илэрсэн гаж нөлөөний үзүүлэлт нь 2022 оны тайланд мэдээлснээр нийт эмийн гаж нөлөөний 52,4%-ийг эзэлж байсан бол 2023 онд 54,6% байгаа нь 2,2%-иар өссөн байна. Гэвч эмнэлгүүдийн тайлагналттай холбоотойгоор антибиотик эмэнд илэрсэн гаж нөлөөний тоог нийт эмийн гаж нөлөөний үзүүлэлтэд тусгахгүйгээр мэдээлж буй тохиолдол цөөнгүй байгаа нь үр дүнгийн үнэн магадлалд нөлөөлж болзошгүй. /Зураг 3/




Зураг 3. Нийт эмэнд эзлэх антибиотикийн гаж нөлөөний үзүүлэлт

Гэвч нийт илэрсэн гаж нөлөөний тооноос антибиотик эмэнд илэрсэн гаж нөлөөний тоо давж мэдээлэгдсэн үзүүлэлтүүд нь үнэлэх боломжгүй байна.

Жишээ нь: Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн 4, хувийн эмнэлгийн 2 байгууллага буюу нийт тайлан мэдээлсэн хувьд нийт эмэнд илэрсэн гаж нөлөө 6 боловч антибиотик эмэнд илэрсэн гаж нөлөө 19 гэж дараах байдлаар тайлагнасан. Тайлан илгээсэн 61 эмнэлгийн 6 (9,8%) нь гаж нөлөөний мэдээллийг зөрүүтэй буюу нийт эмийн гаж нөлөөний тоонд, антибиотик эмийн гаж нөлөөг оруулаагүй мэдээлсэн байна.

ЭЭХХЗГ-т тохиолдол бүрэн мэдээлэлтийн үзүүлэлт




Зураг 3. Эмнэлэгт бүртгэгдсэн гаж нөлөөний тохиолдлыг ЭЭХХЗГ-т бүрэн мэдээлэлтийн үзүүлэлт

Үүнээс гадна эмийн гаж нөлөөний тохиолдлыг эмнэлгийн мэргэжилтэн бүр цахимаар мэдээлэх боломжтой болсонтой холбогдуулан, эмнэлгийн эмзүйн албанд бүртгэгдээгүй шууд ЭЭХХЗГ-ийн мэдээний санд мэдээлэгдсэн тохиолдол тусгай мэргэжлийн төвөөс 16, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-өөс 24 тохиолдол байна. Хүснэгт 1.

Хүснэгт 1. Гаж нөлөөний мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн байдал, ЭМБ

Эрүүл мэндийн байгууллагын төрөл	Тохиолдлыг бүрэн мэдээлэгдсэн үзүүлэлт, хувь	Тайланд мэдээлсэн нийт эмийн гаж нөлөөний тоо	Антибиотик эмийн гаж нөлөөний тоо, эзлэх хувь	Буруу тайлагнасан ЭМБ-ын тоо, хувь	Үндэсний мэдээний санд бүртгэгдсэн гаж нөлөөний тоо	Эмнэлгийн тайланд тусгагдаагүй шууд мэдээлэгдсэн гаж нөлөөний тоо
Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг (N=)	65.5	29	18 (62%)	0	19	0
Тусгай мэргэжлийн төв (N=8)	71.7	53	34 (64%)	0	54	16
Аймаг, Дүүргийн НЭ, БОЭТ (N=27)	73.1	26	17 (65%)	4 (14.8%)	43	24
Хувийн эмнэлэг (N=16)	97.0	33	8 (24.2%)	2 (12.5%)	32	0
	76.6	141	77 (54.6%)	6 (10.3%)	148	40

Үндэсний мэдээний санд бүртгэгдсэн эмийн гаж нөлөөний нийт мэдээллийг фармакологи ангиллаар харвал антибиотик эмийн гаж нөлөө 38,4%-ийг эзэлж байгаа бол тайлан ирүүлсэн эрүүл мэндийн байгууллагын гаж нөлөөний тохиолдлын 52,44%-ийг тус ангиллын эмэнд илэрсэн гаж нөлөө эзэлж байна. Зураг 4

**Зураг 4.** Гаж нөлөө илэрсэн эм, АТС ангиллаар

Доорх зурагт харуулснаар нийт бүртгэгдсэн гаж нөлөөний тохиолдлын 84%-нь эдгэрсэн, 9% нь үргэлжилж байгаа, 3%-нь эмнэлэгт хэвтэх хугацаа уртасгасан, 2% нь үлдэцтэй эдгэрсэн, тодорхойгүй болон нас баралтаар төгссөн тохиолдол тус бүр 1%-ийг эзэлж байна.



Зураг 5. Эм-Гаж нөлөөний тохиолдлын төгсгөл

БИЧМЭЛ ТАЙЛАН (ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАВСРАЛТ 5) 2023 ОН

Нэгтгэл:

- ЭЭЗХ-ны 5 дугаар хавсралт тайланг орон нутаг 14, дүүргийн ЭМТ ба нэгдсэн эмнэлэг-14, тусгай мэргэшлийн 15, хувийн хэвшлийн 11, нийт 57 эмнэлгээс ирүүлснээс эмнэлэгт хэрэглэж буй эмийн чанартай холбоотой мэдээллийг 46 эмнэлэг ирүүлж, 14 эмнэлэг холбогдох мэдээлэл ирүүлээгүй байна.
- Эмнэлэгт хэрэглэж буй эмийн чанарыг хадгалах, чанартай эмээр эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд эмнэлгүүдийн нийтлэг хийсэн ажлуудад дараах үйл ажиллагаанууд багтаж байв. Үүнд:
 - Тендер болон тендер бусаар ирж байгаа эмийг эмийн бүртгэлийн мэдээний санд бүртгэлтэй эсэх дээр хайрцаг, сери дугаар хугацаа зэргийг тулгаж хардаг болсон.
 - Цахим жорын хяналт дээр UpToDate программ ашиглан эм, эмийн харилцан үйлчлэлийг үнэлж эмч мэргэжилтэнг мэдээллээр хангаж ажилдаг болсон байна.
 - Өндөр эрсдэлтэй эм адил харагддаг, адил дуудагддаг эмийн жагсаалт боловсруулан тасаг нэгжид байршуулан хяналт хийж эмнэлгийн мэргэжилтэнг мэдээллээр хангаж ажиллаж байна.
 - Эм, эмнэлгийн хэрэгслийг тендрийн гэрээт байгууллагуудаас татан авснаар чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй эм татан авахаас сэргийлэх
 - Татан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн чанарыг харааны мэдрэхүйгээр шалган хүлээн авч, хагарч гэмтэх гэх мэт чанарын асуудал гарсан эмийг буцаах, солиулах
 - Эмийн чанарыг алдагдуулахгүйн тулд эмийн агуулах, хөргөгчний чийг дулааныг тогтмол шалгаж, тэмдэглэл хөтлөх, тогтмол хяналт тавих
 - Эмийн хүчинтэй хугацааны хяналтыг тогтмол хийж, хүчинтэй хугацааны самбар хөтлөн, эмийн хүчинтэй хугацаа дууссанаар чанар нь алдагдах эрсдэлээс сэргийлэх

Дүгнэлт

1. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны тайланг 2023 оны байдлаар нийт 87 эрүүл мэндийн байгууллага тайлагнаж ирүүлэхээс 61 (70.1%) тайлагнасан ба өмнөх оны тайлантай харьцуулахад тайлан ирүүлсэн эрүүл мэндийн байгууллага 4,6% аар илүү байгаа боловч тайлан алдаатай мэдээлэл дутуу, тайлан ирүүлдэггүй байдал нь өмнөх онтой харьцуулахад сайжраагүй байна.

2. 2023 онд нийт 573,425 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлж, түүний 25.1%-д нянгийн эсрэг эмийг эмчилгээнд хэрэглэсэн ба өмнөх онтой харьцуулахад 2.3%-иар буурсан боловч тарилгын эмийн эзлэх хувь 66% байсан бол энэ онд 68% болж ихэссэн төлөвтэй байна.

3. ДЭМБ-ын өдрийн тунлагдсан тооцооллоор /ӨТТ/ 100 ор хоногт тооцон хэрэглээг үнэлсэн. Тус онд нянгийн эсрэг эмийн хэрэглээ 2804.65 ӨТТ/100 ор хоног гарсан ба өмнөх оноос буурсан байна.

4. Хэрэглээг ДЭМБ-ын AWARE (хүртээмжтэй байлгах, хянах, нөөцлөх) ангиллын дагуу үнэлэхэд өмнөх оноос хүртээмжтэй байлгах бүлгийн хэрэглээ буурч, хянах бүлгийн хэрэглээ ихэсч, нөөцлөх бүлгийн хэрэглээ хэвийн үзүүлэлттэй гарсан.

5. Энэ оны байдлаар эмнэлэгт бүртгэгдсэн эмийн гаж нөлөөний тохиолдлын 76,8%-ийг ЭЭХХЗГ-т мэдээлсэн үзүүлэлт нь өмнөх оноос даруй 37,1%-иар нэмэгдсэн үзүүлэлт нь эрүүл мэндийн байгууллагуудад эмийн гаж нөлөө мэдээлэх цахим системийн хэрэглээ, журмын хэрэгжилт харьцангуй сайжирсан байгаа нь харагдаж байна. Энэ нь эмийн гаж нөлөөг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авах, эмийн аюулгүй байдалд тавих хяналт, зохицуулалтын шийдвэр гаргах зэрэгт нотолгоонд суурилсан тохиолдол, мэдээллээр хангахад эергээр нөлөөлж буй сайн үзүүлэлт болж байна.

6. Нийт гаж нөлөөний тохиолдлын 56,4%-ийг антибиотик эмэнд илэрсэн гаж нөлөөний тохиолдол эзэлж буй нь үндэсний мэдээний сан (38.4%) болон олон улсын мэдээний сантай (34%) харьцуулахад өндөр байна. Энэ нь эмнэлгийн тусламж үйлчилгээнд антибиотикийн сонголт, хэрэглээ өндөр байгаатай холбоотой хэдий ч харшил төрүүлэх шинж чанар өндөртэй учир эмчилгээг эхлэхийн өмнө харшлын сорилын техникт онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

7. Мөн үндэсний мэдээний санд бүртгэгдсэн гаж нөлөөний тоо нь эмнэлгээс ирүүлсэн тайлантай зөрж байгаа нь эмнэлгийн эмзүйн албаны фармаковижиланс хариуцсан мэргэжилтэн тасаг нэгж бүрээс мэдээлэгдсэн тохиолдлыг тогтмол бүртгэж, мэдээний сангаа баяжуулан, оны эцэст тайланд бүрэн тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Д.Алимаа ЭЭХХЗГ-ын
/Эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч/

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанарын хяналтын газраас эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллагад Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн хяналтын шалгалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт, шалгалт хийж байна.

2024 оны эхний 6 сарын байдлаар 767 эрүүл мэнд, эмийн хангамжийн байгууллагад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудад дараах зөрчил дутагдлууд нийтлэгээр илэрсэн байна. Үүнд:

- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг үндэслэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулж дотоод хяналт хийх журам төлөвлөгөө боловсруулаагүй, хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнг тооцдоггүй;
- Жороор олгох эмийг жоргүйгээр, шаардлага хангахгүй жороор олгосон;
- Эмийн гаж нөлөө илрэх үед зохих арга хэмжээг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааны удирдамжийг боловсруулж, мөрдөн ажилладаггүй;
- Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл хийж, бүртгэл хөтөлдөггүй;
- Татан авч байгаа буюу нийлүүлж буй эм, эмнэлгийн хэрэгслийн тээвэрлэлт, түгээлтийн байдалд хяналт тавьж, баримтжуулаагүй;
- Эмийн эмчилгээний үр дүнг тооцон эмийн хэрэглээг үнэлэх, эмчилгээний алдаа дутагдлаас сэргийлэх чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаа дутагдалтай;
- Нянгийн эсрэг үйлчлэлтэй эмийн эмчилгээний үндэслэл, зохистой хэрэглээ, жор бичилтийг сайжруулах талаар эмч, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, ажил зохион байгуулж, үр дүнг тооцдоггүй;


Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг үндэслэн Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд 48 зөрчлийг хялбаршуулсан журмаар, 14 зөрчлийг зөрчлийн хэрэг нээн, 3 зөрчлийг харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлэсэн бөгөөд 62 байгууллага, иргэнд 43 сая төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, 39,1 сая төгрөгийн хууль бусаар олсон мөнгөн орлогыг улсын төсөвт нөхөн төлүүлсэн.

Мөн хяналт шалгалтын явцад Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, бүртгэлийн загвараас зөрүүтэй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, хадгалалтын горим алдагдсан зэрэг зөрчилтэй бүтээгдэхүүнийг илрүүлж зөвлөлд шилжүүлэн устгуулсан бөгөөд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр улсын /ахлах/ байцаагчийн 2031 заалт бүхий 216 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулан ажиллаж байна.

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

А.Номиндарь ЭЭХХЗГ-ын
/Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт
хариуцсан мэргэжилтэн/


Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн төсөв, тендерийн гүйцэтгэл: Төсвийн гүйцэтгэл нь 2019 онд 76%, 2020 онд 66%, 2021 онд 80%, 2022 онд 77%, 2023 онд 93.2% тус тус байлаа.




2023 оны ТӨЭМБ-ын худалдан авалт төрлөөр: Эм 96,3 тэрбум (40%), төлбөрийг нь төр хариуцах эм 12,3 тэрбум (5%), эмнэлгийн хэрэгсэл 71,016 тэрбум (30%), нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл 4,5 тэрбум (2%) урвалж оношлуур 49,9 тэрбум (21%), вакцин 6.9 тэрбум (3%) төгрөгийн худалдан авалт хийсэн байна.



Ерөнхий гэрээний хэмнэлт: Ерөнхий гэрээгээр 45.4 тэрбум төгрөгийн захиалга хийгдэж 2.8 тэрбм төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт оруулжээ. Ерөнхий гэрээний эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт 2023 онд ТӨЭМБ-ын нийт эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын 18.7 хувийг эзэлж байна.



Ерөнхий гэрээний худалдан авалт: 2023 онд Ерөнхий гэрээний эмийн худалдан авалтад /18 байгууллага/ оролцож 6.4 тэрбум төгрөгийн худалдан авалтыг хийжээ.



ТӨЭМБ-уудын тендерийн 2023 онд худалдан авалт, улс орноор:

ТӨЭМБ-ын тендерт 48 улсын эм шалгарсан байна. Үүнээс: ML3 болон ML-тэй улсын эм-16.19%, WLA жагсаалтанд орсон улсын эм: 19.86%, Бусад орны эм- 45.97%, Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн-18.85% байна.

№	Улс	Нийт дүн	Хувь
1	Монгол	6,715,098,903	20.4%
2	БНЭУ	5,003,715,464	14.0%
3	БНСУ	3,851,329,680	10.8%
4	ОХУ	2,831,057,140	7.9%
5	Индонез	2,733,504,240	7.6%
6	БНХАУ	2,423,668,319	6.8%
7	Турк	1,875,347,975	5.3%
8	Испани	1,538,525,901	4.3%
9	Словени	1,294,158,823	3.6%
10	Герман	815,427,264	2.3%
11	Тайвань	684,448,430	1.9%
12	Швейцари	655,356,325	1.8%
13	Итали	652,890,263	1.8%
14	Франц	602,174,414	1.6%
15	Унгар	528,521,785	1.4%
16	Дани	514,273,140	1.4%
17	Япон	428,250,716	1.2%
18	Австри	414,066,040	1.7%
19	Беларусь	349,702,690	0.9%
20	Украин	328,864,830	0.9%

ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

УЛАМЖЛАЛТ ЭМИЙГ УУЖ ХЭРЭГЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

АУ-ны доктор, профессор С.Сээсрэгдорж

Эмэн эмчилгээ болон химийн бодис, мэс ажилбараар эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед гарч болох эмчилгээний зорилгод нийцээгүй эмгэг өөрчлөлт бий болох үзэгдлийг “seper (adverse) нөлөө” хэмээн үздэг.

Эмийн гаж нөлөөний талаар нарийнчлан судалдаг эм судлалын нэг салбарыг фармаковижиланс гэдэг бөгөөд энэ салбар нь эмийн фармакокинетикийн болон фармакодинамикийн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан эм, биобэлдмэл, эмийн ургамал, уламжлалт эмтэй холбоотой хүний эрүүл мэндэд үзүүлэх халгаат хүчин зүйлүүдийн гарал, үүслийг илрүүлэн гаргаж, түүнд үнэлгээ дүгнэлт өгөх, түүнээс урьдчилан сэргийлэх арга аргачлалыг боловсруулах цогц арга хэмжээг авч үздэг. / **(Medical letter on Drug and Therapeutics. 2005)**

Орчин үеийн эм судлалын энэ салбарын судлагдахуун болох хэсэг бол манай эрүүл мэндийн системийн хувьд монгол уламжлалт эмийн зохист хэрэглээ түүний үр дүн ямар байгаад анхаарал хандуулах ёстой болдог. Монгол уламжлалт анагаах ухаан богино хугацаанд эргэн сэргэж амжилттай хөгжиж буйч монгол уламжлалт эмийг хэрэглэх мэдлэг, чадвар ард иргэдийн дунд хангалттай биш байна. Уламжлалт анагаах ухааны эмийн эмчилгээний хэрэглээ өсөн нэмэгдэж байгаагийн зэрэгцээ түүний аюулгүй байдал, үр дүнтэй, чанартай байдлыг баталгаажуулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх асуудал чухал байгаа юм. Ард иргэдийн дунд уламжлалт эм, ургамлын гаралтай эмийн бүтээгдэхүүнийг хоргүй аюулгүй гэх ойлголт түгээмэл байдаг нь буруу юм.

Уламжлалт эмийн зохист хэрэглээ нь эмчид үзүүлж онош тогтоолгохоос эхлээд хаагуур хэрхэн яаж хэрэглэх, тэр үеийн идээ, ундаа, явдал мөрийн дэглэм, цээр гам, ууж хэрэглэх ёс, туйплан, эрдэнийн эм уух зэргийг хамарсан өргөн хүрээтэй асуудал бөгөөд энэ удаа бид уламжлалт эмийг зөвхөн уух зохист хэрэглээний талаар орчин үеийн эм судлалын хүрээнд баримталж буй зарчмуудтай уялдуулан авч үзэхийг зорилго болголоо.

Монгол уламжлалт анагаах ухаанд эмийн хэрэглээг эрт дээр үеэс онцгой анхаарч үе уламжлан хатуу чанд дагаж мөрдөж ирсэн тангараг, зарчимтай байдаг. Тухайлбал: Уламжлалт эмчийн тангарагт “Найрлага хэмжээг нь бүрэн бүрдүүлж ёсчлон найруулсан эмүүдийг хүссэн хэрэг бүгдийг сэтгэлчлэн бүтээгч чандмань эрдэнэ хэмээн сэтгэж үйлдэнэ. Үүний тул: Эм найруулахдаа мэргэд нарын уламжилж ирснээр ёсчлон найруулж өөрийн биеийг “Биндэръяа”-гийн гэрэлт хааны чанарт үүсгэн адистидын хүчийг оруулаад эмийн савыг рашаан агуулсан бадар аягаар сэтгэн өвчин, ад, зэтгэрийг анагаан арилгаж үхлээс аврагч рашаан боллоо хэмээн бясалган сэтгэж үйлдэнэ. Ёсчлон найруулж адистидалсан эмийн дээжийг багш, бурхан, сахиус, аршуудад тахил болгон өргөж буян хураах зэрэг болно” хэмээн заасан байдаг. Энэ нь эмийг чандмана эрдэнэтэй зүйрлэн дээдэлж түүний бүрэлдэхүүнийг хуурмаггүйгээр бүрдүүлж багш нараас уламжилж ирсэн технологийн дагуу ёсчлон найруулж тарниар хүч оруулж хуурамч биш эм болсныг бурхан, сахиуснууддаа тангараг болгож өргөж буйг илэрхийлдэг. **(Дарамаарамба Лувсанчойдог “Алтан хадмал” Эмчийн 31-р бүлэг)**

Нөгөө талаар эмийн хэрэглээтэй холбоотой “Өвчнөө таньсан боловч эмчлэх эм, аргаа мэдэхгүй эмч бол харанхуйд сум харвахын адил ерөндөг нь өвчнийхөө дээр үл буух болно. Идээ, ундаа явдал мөрийг мэдэхгүй эмч бол өөрийн нөхрийг дайсан болгож хувиргахын адил өвчний хүчийг үлэмж нэмэгдүүлэх болно. Амарлиулах эмийн 10 найрлагыг мэдэхгүй

эмч бол дөрвөн улиралд ялгаж тарих тариаг мэдэхгүйгээр солбиж тарьсантай адил ерөндгийг илүүдүүлэх, дутаах, буруудуулах мэтээр өвчний хүчийг нэмэгдүүлнэ. Арилгах таван үйлийн эмийг мэдэхгүй эмч бол элсэнд ус хийгээд хоёулаа алга болохын адил өвчин хийгээд биеийн тамирыг эмийн хүчээр дарах болно” хэмээн МТ8-р зууны дунд үед бичигдсэн “Эмийн дөрвөн үндэс” хэмээх сурвалж бичигт заасныг өнөөдөрт ч мөрдлөг болгож байна.

Монгол уламжлалт анагаах ухааны эдгээр тангараг, зарчмууд нь өнөөгийн эм судлалын шинжлэх ухааны “дагалдах нөлөө”-г эмчилгээний эхэнд эсвэл эмчилгээний явц дунд, эмчилгээний төгсгөлд, эмчилгээ дууссаны дараа ч илэрч болох “эмийн нөлөө” (**Adverse Drug Reaction**), эсвэл эмчилгээний арга барил буюу эмчтэй холбоотой илрэх сөрөг нөлөөг “эмчилгээний гаж нөлөө” (**latirogenic Adverse Effect**) гэж АНУ-ын Хүнс Эмийн Удирдах Газар (FDA)- аас эхлэн гаргадаг “Medical Letter” сэтгүүлд тодорхойлсон байдагтай дүйж байдаг.

Өнөөдөр эмийн зохист хэрэглээний талаар дараах зарчмыг мөрдлөг болгож байна. Үүнд:

Зарчим 1.

Эмийн шаардлагагүй хэрэглээнээс зайлсхийж өөрөө дур мэдэн үл ялиг зүйлд сонсноороо, аялдан дагалдаж, таамгаар эм хэрэглэхгүй байх ёстой. Манай орны нөхцөлд дур мэдэн эм хэрэглэх боломж өргөн байдаг. Эмийн түүхий эдийг жижгээр савлаад хаа сайгүй эмийн ямарч баталгаа, хяналтгүйгээр зарж бид авч хэрэглэж буй нь эмийн хэрэглээний хувьдч, эмийн түүхий эдийг бэлтгэх технологи, эмийн түүхий эдийн нөөцийн хувьдч харамсалтай байдаг.

Дур мэдэн эм хэрэглэснээс үүсэж болох эрсдлийг монгол анагаах ухаанд махбодио хямралдуулах, илүүдүүлэх, дутаах, тамираа барах түүгээр үл барам найрлага адил болсон буюу гал дээр тос нэмсэн мэт өвчний хүчийг улам дэвэргэж ямарч эм, эмчилгээ авахгүйгээр үхэлд хүргэдэг амийг булаах есөн өвчний нэг болно гэж үзсэн байдгийг онцгой анхаарах ёстой.

Зарчим 2.

Хэрэв эм хэрэглэх шаардлагатай гэж үзвэл уламжлалтын эмчид үзүүлж оношоо заавал тогтоолгоод тэр өвчнийг анагаах тодорхой зарчмын дагуу эм хэрэглэх ёстой. Эм бол бусдаас ялгаатай, онцгой бүтээгдэхүүн учир эмч мэргэжилтний зөвлөгөөг сайтар дагаж мөрдөж, эмийн талаар аль болох бодит мэдээлэл авахад анхаарах ёстой.

Эмч тавьсан оношийн дагуу эмийг жорыг заавал бичиж өгөх ёстой. Орчин үеийн ч юм уу уламжлалт ч юм уу эм гэж байгаа бол заавал жороор олгодгийг эмч, үйлчлүүлэгч анхаарах ёстой. Жор нь орчин үеийн эмийн жор бичих стандарт ёсоор бичигдсэн байх бөгөөд жорын дагуу баталгаатай эмийн сангаас эмээ авч хэрэглэх ёстой. “Эмийн жор” бол эмчээс эм зүйч, эм найруулагчид хандан бичсэн, эмийг тухайн өвчтөнд зориулан хэрхэн хэрэглэх аргыг заасан баримт бичиг юм. Эмийн жорд эмийн нэр уух тун хэмжээ өдөрт хэдэн удаа нийт хэд хоног хэрхэн яаж хэрэглэхийг заасан хариуцлагатай баталгаа, нотолгоо бүхий баримт бичиг.

Өөрөөр хэлбэл эмч мэргэжилтэн өвчтэй хүнд бүрэн тохирох эмийг сонгож, хэрэглэх аргыг зөв тодорхойлсноор эмчилгээ үр дүнтэй болдог тул эмийг заавал эмчийн жорын дагуу эмийг зөв хэрэглэснээр өвчин эмгэг түргэн илаарьшиж, үлдэгдэлгүй эдгэх нөхцөл бололцоо бүрддэг.

Орчин үед эмийн худалдаа ба хэрэглээний практикт эмийг ерөнхий буюу олон улсын нэр, худалдааны буюу патентын /фирмийн/ гэсэн хоёр төрлийн нэрээр нэрлэж хэвшсэн байдаг. Харин монгол уламжлалт эмийн нэршлийн талаар анхаарах зүйлүүд бий. Монгол

уламжлалт анагаах ухааны эмийн нэршлийн стандарт хэв загвар батлагдаагүй учир 1. Зарим эм ёгт нэрээр 2. Зарим эм нууц нэрээр 3. Заримдаа төвөд галигаар 4. Заримдаа монгол нэрээр орчуулсан байдлаар байх тул эмийг давхардуулж хэрэглэх, эсвэл илүү урт хугацаагаар хэрэглэх магадлал байж болохыг анхаарч асууж лавлах ёстой.

Зарчим 3.

Ямар ч эмийг хэрэглэхийн өмнө заавартай нь сайтар танилцах нь таныг эрсдэлээс хамгаалдаг. Монгол уламжлалт эмийн хувьд энэ нь нэлээд товчхон эмийн хайрцаг сав багалаа боодол дээр бичигддэг. Ер нь эмийн заавар хэрэглэгчдэд зориулсан, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан гэж хоёр янз байдаг. Эмийн зааварт

- үйлдвэрлэгчийн нэр, албан ёсны хаяг
- эмийн худалдааны болон олон улсын нэр
- эмийн найрлага, тун хэмжээ
- эмийн хэлбэр, өнгө, үнэр
- эмийн үйлдэл
- хэрэглэх заалт ямар өвчинд хэрэглэх,
- хориглох заалт /ямар хүнд тохирохгүй байх тухай/
- гаж нөлөө
- бусад эмтэй харилцан үйлчлэл
- хэрэглэх арга
- савлалт, хүчинтэй хугацаа
- хадгалах нөхцөл, анхааруулга
- олгох нөхцөл зэргийг тайлбарлаж бичсэн байдгийг анхаарах ёстой.

Зарчим 4.

Эм хэрэглэх аргад сайтар суралц. Энэ нь эмийг ямар аргаар яаж хэрэглэх буюу хэрэглэх арга техник, ямар хугацаанд хэрхэн хэрэглэх/ хэрэглэх цаг, үечлэл, завсарлага, хэдий хугацаагаар үргэлжлүүлэх гэх мэт/, хамт хэрэглэж болох болохгүй хоол хүнс, эмийн бодис, эм хэрэглэж байх үед зөвшөөрөгдөхгүй ажил хөдөлмөр, үйл ажиллагаа, эмчилгээ хийгдэж байх үедээ өөрийгөө хянах, анхаарах зүйлс зэрэг өргөн хүрээний ойлголтууд багтдаг. Эдгээр ойлголт нэг бүрийг аль болохоор тодруулах нь зүйтэй юм. Үүний тулд заримдаа эмч, эмийн мэргэжилтний зөвлөгөө авах нь чухал байдаг.

Зарчим 5.

Эм уух дэглэм, цаг хугацааг ягштал баримтал. Монгол уламжлалт анагаах ухааны эм ууж хэрэглэх ёс нь эртнээс нааш нарийн зүй тогтол, дэг жаягтай өөрийн өвөрмөц онцлог бүхий итгэл үнэмшил, баталгаа, нотолгоотой мөрдөгдөж ирсэн байдаг. Энэхүү арга нь өнөөгийн био-анагаах ухааны биохэмнэл, эм судлалын хронофармокодинамик, хронофармакокинетикийн асуудлуудыг өөртөө агуулж байгаа төдийгүй нарийн нягт уялдаатай байдаг нь гайхамшигтай юм.

Монгол уламжлалт эмийг ууж хэрэглэхэд дагаж мөрдөж ирсэн арван ёс нь өдөр, хоног, идээний цаг, өвчинтэй нэгдмэл хамааралтай хүний бие махбодын хоногийн био хэмнэлтэй холбоотой байдаг.

1. **Өлөн дээр уулгах:** Хорхой, бадганы хувь их буюу бадган хүйтний хүч ихдэж цагаас хэтэрсэн боловч өвчний тамир хүч нь сайн бол өглөө эрт хоол идүүлэхгүйгээр эм уулгаж, түр хугацаанд хоол идүүлэхгүй байлгана. Энэ нь өглөөний цайнаас 30 минутын өмнө ууна гэсэн үг.

2. **Идээний өмнө уулгах:** Тамирыг сайжруулах, уруу арилгах хий өвчний эмийг идээний өмнө уулгаж, даруйд нь хоол идүүлнэ. /25-30 минутын өмнө/
3. **Идээний дунд уулгах:** Гал тэгшитгэгч хий өвчний эмийг цагийн хоолыг хагас идүүлж уулгаад, дараа нь дахин хоолыг нь идүүлнэ.
4. **Идээний хойно уулгах:** Түгээмэл гүйгч хийн өвчинг анагаахад эрт оройн хоолыг идсэний дараа эмээ уулгана./40-60 минут/
5. **Идээтэй ээлжлэн уулгах:** Амь баригч хийн өвчинг анагаах эмийг нэг үмх хоол идүүлж, эмээ уулгах мэтээр бага багаар ээлжлэн уулгана.
6. **Идээний завсар уулгах:** Дээш гүйгч хийн өвчинг анагаахад идээ шингэсэн үед уулгана. Идээнээс хойш 2-3 цаг болоод уух.
7. **Тогтмол цаггүйгээр дахин давтан уулгах:** Хордлого тайлах болон бөөлжүүлэх үйлчилгээтэй ба амьсгал давхцах, ундаасах, ам цангах өвчин, цэр хөөх үйлчилгээтэй эмүүдийг хоол идсэн эсэхтэй хамааралгүй бага тунгаар дахин давтаж уулгана.
8. **Идээтэй хольж уулгах:** Хоолондоо дургүй болох хам шинжийн эмийг зохист идээтэй хольж уулгана.
9. **Хоолыг хавчиж уулгах:** Хоолны дуршил муудсан ба зогисох хам шинжийг анагаах эмийг хоолны өмнө болон дараа нь хавчиж уулгана.
10. **Шөнө уулгах:** Нүдний өвчний эмүүд, цэр ховхлох, хортой, цочроох үйлдэлтэй болон тайвшруулах эмүүдийг шөнө унтах үед уулгана. Өвчний бодит байдлыг үндэслэн эм уух цагийг өөрчилж хүнд, цочмог өвчний эмийг тухайн цагт нь уулгана. Мөн тогтмол ба зарим цаг бусаар хөдөлдөг өвчнүүдийн эмийг хөдлөхөөс өмнө урьдчилан сэргийлэх байдлаар уулгана.

Зарчим 6.

Эмийн нэр, хэлбэр, тунг хэрэглэхийн өмнө заавал уншиж бай. Монгол уламжлалт эм хэлбэрээс хамаарч уух арга, ёс нь өөр байдаг төдийгүй эмийн хэлбэрээсээ хамаарч эмийн үйлдэл нь өөр байдгийг сайтар анхаарах ёстой байдаг. Монгол анагаах ухаанд эмийн 10 хэлбэр байдгийг дагаж мөрдөж ирсэн.



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



**ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ
УРВАЛ ХҮНДРЭЛ /ДДУХ/ ОЛОН
ХОНОГООР ҮРГЭЛЖИЛЖ
ХҮНДЭРВЭЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГАД МЭДЭЭЛЭЭРЭЙ.**



ЯДРАХ



НУС ГООЖИХ



БУЛЧИН ӨВДӨХ



ХУУРАЙ ХАНИАЛГА



ТОЛГОЙ ӨВДӨХ



ХАЛУУРАХ

Уламжлалт эмийн хэлбэр ба үйлдэл

№	Эмийн нэр	Эмийн хэлбэр	Үйлдэл, заалт
1	Тан	Бүдүүн ширхэгтэй	Тан эм нь шингэхэд хялбар, түргэн үйлдэл үзүүлэх онцлогтой, хурц ба архаг чанартай өвчинд хэрэглэх ба боловсруулах, хураах, ялгах, хөлрүүлэх зэрэг үйлдэлтэй.
2	Талх	Маш нарийн нунтаг	Уухад хялбар, үйлдэл үзүүлэх нь түргэн, хэрэглэх үед буцалсан бүлээн ус, буцалсан хүйтэн ус зэргийг өвчинтэй нь зохицуулан шууд тааруулж уулгана.
3	Үрэл	Нэг буюу олон зүйлийн эмт бодисыг нунтаглаж үрэлдсэн бөмбөлөг хэлбэртэй хатуу биет	Хортой эм, эрдэнийн эм, ховор чухал эм багтдаг. Эмийн шингээлт нь удаан, уухад тохиромжтой, үйлдэл нь удаан бөгөөд архаг өвчинд хэрэглэхэд зохимжтой байдаг.
4	Үнсэн эм	Ёсчлон түлсэн үнсэн эм	Голдуу цайвар бадган, бэтэг, хаван зэрэг хүйтэн чанартай өвчинд тустай.
5	Зуурмал эм	Эмт бодисыг нарийн талхдаж, шар тосонд зуурсан хагас хатуулаг эм	Судал, үес, арьс зэрэгт хуучирч шунасан өвчний урхгийг гаргахад сайн. Өндөр настан, удаан хугацаагаар хэвтэрт байсан, тамир дорой хүмүүст тохиромжтой.
6	Архин эм	Эмт бодисыг чанах юм уу дэвтээж шүүсийг нь гарган хөрөнгө сэлбэж нэрсэн шингэн эм	Илчийг сэлбэх, дур нээж, шингээлт сайжруулах, бадган хийг арилгах, яс шөрмөс гэмтсэнийг анагаах, бөөрний тамир сэлбэх, цусны гүйдэл сайжруулах, хөшсөнийг зөөлрүүлэх үйлдэлтэй.
7	Хандан эм	Эмт бодисыг чанаж, ширгээж өтгөрүүлсэн хагас хатуулаг хэлбэр	Үйлдэл нь хурц, өвчнийг анагаахад сайн, яр шарх, хавдарт гадуур хэрэглэх ба халуун өвчинд хэрэглэнэ.
8	Эрдэнийн эм	Алт, мөнгө, төмөр зэрэг үртсээр голлож найруулсан хүч ихтэй үрлэн эм	Амирлуулах эмийн бурууг дарах хаан эм. Усан, суваг хаван, чийх, сахуу, боом, мэдрэлийн ба уяман өвчин, шар усны өвчин, шимжүүлэх, хүчжүүлэх үйлдэлтэй.
9	Өвсөн эм	Өвсөн ургамлыг гол болон хөл эм болгосон эм	Цул, савын аль ч эрхтэнд жолоодлого эмийг нэмж өгнө.
10	Тосон эм	2-оос дээш эмт бодисыг чанаж, шүүсийг үнээний сүү, шар тосонд чанаж ширгээсэн хагас хатуу биет	Биеийг шимжүүлэх, тамиржуулах, эрхтнүүдийн чадварыг нэмэгдүүлэх, атирч хөшсөнийг зөөлрүүлэх үйлдэлтэй.

Эмийн хэлбэрүүдтэй холбоотой уух арга

№	Эмийн нэр	Өгөх арга
1	Тан	Тан эмийг усанд хийж зөөлөн галаар 2/3-ийг ширгээж халуун, хүйтэн, бүлээнээр өвчиндөө тохируулан ууна. Олон цагаар дэвтээж ууж болно.
2	Талх	Талх эмийг буцалгасан ус ба эмчийн тогтоосон хөлгөөр даруулж уулгах буюу бүрж уулгана.
3	Үрэл	Үрэл эмийг буцалсан ус ба тусгай хөлгөөр даруулж хоолны дараа ууна. Биеийн тамир, ходоодны галын илч сайн хүн хөнгөн өвчтөн бол боломжит үрлийг залгиж ууна. Ходоодны галын илч бага настайчууд, өвчин хүнд бол үрэл эмийг усанд хийж дэвтээж зөөлрүүлж эсвэл зажилж ууна. Өвчин хүнд биеийн тамир болон галын илч муу бол үрлээ нунтаглаж талх болгоод ууна.
4	Үнсэн эм	Өдөрт 1-2 удаа 1.5-3 гр-г тохирх хөлгөөр даруулж ууна.
5	Зуурмал эм	Өдөрт 1-2 удаа 1-3 гр-ийг зохих хэмжээний ширгээсэн бүлээн усаар ууна.
6	Архин эм	Үдэш унтахын өмнө 50-100 мл ууна.
7	Хандан эм	Хандыг уух, түрхэх, хөхүүлэх, дусаалга зэргээр хэрэглэдэг.
8	Эрдэнийн эм	Уух өвөрмөц заавартай байдаг.
9	Өвсөн эм	Халуунд хүйтэн, хүйтэнд халуун бүлээн зохих хөлгөөр ууна.
10	Тосон эм	Өглөө хийн цагт 6-8 гр-ийг идүүлж халуун сүү, хярам, ус зэргээр даруулна.

Жич: Үрэл эм: Нэг буюу олон зүйлийн эмт бодисыг нунтаглаж үрлийн голтой нийлүүлэн найруулсан бөмбөлөг хэлбэртэй хатуу биет эмийн хэлбэр юм. Үрэл эм нь ходоодонд аажим задран шингэж үйлдлээ үзүүлэх тул архаг явцтай хурмал чанартай өвчин ба өвдөлт намдаах, бэтэг хайлуулах, өвчний урхгийг таслахад голлон хэрэглэдэг. Үрэл эм хүчтэй үйлчилгээтэй эмт бодисууд нэлээдгүй ордог учир өлөн дээр уудаггүй бөгөөд нэг удаа их тунгаар юм уу ойр ойрхон уудаггүй.

Уламжлалт эмийн тун хэмжээг тохируулах

Ёсчлон найруулсан эмийг өвчтөний тамир тэнхээ, нас, өвчний хүчинд тун хэмжээг тохируулан хэрэглэдэг. Насанд хүрэгсдэд манайд энгийн эмийг дунджаар 1-2гр цөөн тохиолдолд 3 гр-аар ууж байна. Талх эмийн хэмжээ тан эмээсээ бага байж болно гэж үздэг. Харин Гарьд-5, Зачүн-13, Нару-3 зэрэг сэдэлт бүхий үрэл эмийг бага тунгаар хэрэглэх ёстой. Мөн нас ахисан, тамир дорой хүмүүст эмийн хэмжээг харьцангуй бага хэмжээгээр өгч, идэр залуу, тамир тэнхээ сайн хүмүүсийн өвчин нь хүнд бол хэмжээг нэмж өгдөг. Хүүхдэд өгөх эмийн хэмжээг насанд хүрсэн хүний дундаж тунг хүүхдийн настай уялдуулан тогтооно.

Хүүхдийн эмийн ерөнхий тун хэмжээ

Насны хэмжээ	Эм өгөх хэмжээ
Хүүхэд	Насанд хүрэгчдийн хэмжээ 2-3 грамм
1-6 сар хүртэл	1\10- 1\ 8
6 сараас 1 нас хүртэл	1\7
1 наснаас 2 нас хүртэл	1\6
2-4 нас хүртэл	1\5
4-6 нас хүртэл	1\4
6-9 нас хүртэл	1\3
9-15 нас хүртэл	2\3
16-18 нас хүртэл	Насанд хүрсэн хүний адил

Дээрх тунг өвчтэй хүүхдийн махбод болон өвчний байдал ба эмийн хүч, чадлыг үндэслэн зохицуулан хэрэглэнэ.

Зарчим 7.

Монгол уламжлалт эмийг уухдаа эмийн хөлөг, нэмэр, хачрыг анхаарна. Монгол эмэнд тухайн эмийг өвчний голомтод хамгийн хурдан хүргэж үйлдэл үзүүлэх эмийн хөлөг гэж байдаг. Талх, үрэл эмд хөлгийг өргөн хэрэглэнэ. Хөлөгт ширгээсэн ус, тан эмийн шүүс, архи, сүү, ясны шөл, зөгийн бал, мөсөн чихэр, бурам орох бөгөөд өвчний байдалд тохируулан хөлөглөдөг. Үүнийг эмчийн бичиж өгсөн заавраас анхаарна. Тухайлбал: Найрлагын халуун, хүйтэн чанарыг үндэслэн өвчнийг дарах чадлыг нэмэгдүүлэхийн тулд халууныг арилгах талх эмийг ширгээж хөргөсөн усаар, хүйтнийг арилгах талх эмийг ширгээсэн халуун бүлээн усаар даруулж уулгадаг. Жишээ нь Гавар 25-г хүйтэн усаар, Сожиднямынжинхорыг бүлээн сүү, цайгаар даруулна. Өвчний мөн чанар харилцан адилгүй байдагт үндэслэн Гиван 9-г мөсөн чихрээр, Агар-8-г бурмаар хөлөглөнө.

Мөн монгол анагаах ухаанд талх эмийг уулгахдаа өвчний хавсарсан, хурсан урвалт, илүүдэх, дутагдах, буруудахаас сэргийлэн зохицуулах болон өвчин буусан орон, мөн чанарыг үндэслэж эмийн үйлдлийг нэмэгдүүлэхийн тулд нэг эмэн дээр өөр эмийг нэмэр болгож эсвэл хачир болгож хэрэглэдэг. Нэмэр гэдэг нь үндсэн эмтэй тэнцүү хэмжээтэй хачир нь үндсэн эмээс багахан байдаг. Тухайлбал хийгээр сарнисан шарын өвчинд Гарнаг-10 дээр Шижэд-6-г тэнцүү хэмжээгээр нэмж Гарши болгож хэрэглэх эсвэл бөөрний нян бүхий өвчинд Сүгмэл-10 дээр Чун-5-аар хачир тавьж Сүгчун болгох зэргээр олон эмийг хүчийг нэмэгдүүлж хэрэглэж болдог. Нэмэр, хачрийг эмийн жорд тэмдэглэсэн байдаг.

Энэ аргууд нь орчин үеийн эм судлалын хоёр буюу хэд хэдэн эмийг хамт хэрэглэхэд тэдгээр эмүүд нь нэг нэгнийхээ үйлдлийг дэмждэг синергизмтэй адил бөгөөд үйлдлийн механизмын хувьд хоёр эмийн бодис нэг чиглэлтэй үйлдэл үзүүлэхдээ нэг байд нөлөөлж байгаа шууд, хоёр эмийг хамт хэрэглэхэд илрэх үйлдлийн хүч нь тэдгээрийг тус тусад нь хэрэглэхэд гарах үйлдлийн хүчийн нийлбэртэй тэнцүү нийлбэржих, хоёр эмийг хамт хэрэглэхэд илрэх үйлдлийн хүч нь тэдгээрийг тус тусад нь хэрэглэхэд гарах үйлдлийн хүчний нийлбэрээс илүү хүчжих синергизмтэй адил гэж үзэхээр байдаг нь монгол уламжлалт анагаах ухааны эмийн үйлдлийн механизм эртнээс төгс чанартай хөгжиж ирсэн болохыг харуулдаг.

Зарчим 8.

Монгол эмийн үйлдлийн онцлог байдлын талаар ойлголттой байх ёстой. Монгол эмийг хүний биеийн төрөлх өвөрмөц чанарын өөр өөр байдлыг гол цөм болгож хэрэглэж ирсний зэрэгцээ түүнийгээ цаг улирлын хөдлөл зүйтэй хамааруулж нас, хүйс, тухайн хүний биемахбдын тамирын гурван ангилал, хавсарсан хурсан өвчинтэй нь шүтэн барилдуулах болон өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх боломжтой байдаг нь онцлог юм.

Монгол эмийн найрлага голлогч, хавсарсан, нөхөр, замч, нядлагч, мухарт нь эрэгч гэсэн ерөнхий бүрэлдэхүүнтэй байдаг нь ганцхан голомтод чиглэсэн бус бусад эрхтэн махбодын тэнцвэрт байдлыг алдагдуулахаас сэргийлсэн системийн үйлдэлтэй болох нь харагддаг.

Бид энэ удаа уламжлалт эмийг ууж хэрэглэх зохист хэрэглээний талаар бичлээ. Цаашид монгол эмийг бусад аргуудаар хэрэглэх, эм хэрэглэх үеийн идээ ундааны хориг, цээр, гамын талаар, туйплан, эрдэнийн эмийн зохист хэрэглээний олон талт байдал, улирлын хөдлөл зүйтэй холбон өвчнөөс урьдчилан сэргийлэх зохист хэрэглээний талаар цуврал байдлаар бичих нь үр өгөөжтэй гэж үзэж байна.

ЭМИЙН ХЭРЭГЛЭХ ЗААВАР БАТАЛГААЖУУЛАХ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Г.Нарангэрэл ЭЭХХЗГ-ын
/Эмийн сонголтын асуудал хариуцсан мэргэжилтэн/

Хүний эмийн салбар зөвлөлийн Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг нэг асуудал нь эмийн хэрэглэх заавар юм. ЭССЗөвлөл тус оны 9 дүгээр сарын байдлаар нийт 7 удаа хуралдан 757 нэрийн эмийн хэрэглэх зааврын асуудлыг хэлэлцсэн.

Нийт хэлэлцсэн асуудлын буюу 51,3% импортын эмийн асуудал харин вакцины хэрэглэх заавартай холбоотой асуудал 0,26% -ийг эзэлж байгаа нь доорх зургаас харагдаж байна (Зураг 1).



Зураг 1. Эмийн хэрэглэх зааврын асуудлын ангилал, хувиар

Эмийн хэрэглэх зааврын асуудлыг хурал тус бүрээр авч үзэхэд дараах үзүүлэлт гарч байна (Зураг 2).




Зураг 2. Эмийн хэрэглэх заавар, хурал тус бүрээр

Эм судлалын салбар зөвлөлийн хурлын шийдвэр дараах байдлаар гарна. Үүнд:

1. Батлах
2. Засвар хийн батлах
3. Буцаах

Энэхүү шийдвэрийг хурал тус бүрээр дараах зурагт харуулж байна (Зураг 3). Мөн зурагт хурлын шийдвэрээр баталгаажуулах тамга даруулсан эмийн хэрэглэх зааврын мэдээллийг тусгасан. Хурал бүрийн шийдвэрийн дагуу дунджаар 80% нь хэрэглэх зааварт тамга даруулан баталгаажуулдаг байна.



Зураг 3. ЭССЗ-ийн хурлын шийдвэр

Эх сурвалж:

- 2024 оны ЭССЗөвлөлийн хурлын тэмдэглэл
- Эмийн хэрэглэх зааварт тамга дарсан тухай тэмдэглэл

AWARE АНГИЛАЛ

ДЭМБ-ын Зайлшгүй шаардлагатай эм бэлдмэлийн сонголт, хэрэглээний мэргэжилтний хорооноос 2017 онд дэлхийн дахин, үндэсний болон орон нутгийн түвшинд нянгийн эсрэг эмийн менежментийн үйл ажиллагааг дэмжих арга хэрэгсэл болгон AWaRe ангиллыг боловсруулсан.

Энэхүү ангиллаар нянгийн эсрэг эмүүдийг тэсвэржилт үүсгэх нөлөө, зохистой хэрэглээний байдлаас хамааран **хүртээмжтэй байлгах**, **хянах** мөн **нөөцлөх** гэх гурван бүлэгт хуваадаг.

Хүртээмжтэй байлгах буюу **ACCESS** бүлэгт нянгийн тэсвэржилт үүсгэх эрсдэл багатай, халдварын эмчилгээний нэг болон хоёрдугаар эгнээний сонголтын өргөн хүрээний нянгийн эсрэг эмүүд хамаарагддаг. Энэ бүлгийн эмүүдийн ойролцоогоор 60% нь ууж хэрэглэх нянгийн эсрэг эмүүд байдаг.

Хянах буюу **WATCH** бүлэгт явцуу хүрээний, нянгийн тэсвэржилт үүсгэх эрсдэлтэй, хүртээмжтэй байлгах бүлгийн эмүүдийг хэрэглэх боломжгүй тохиолдолд хэрэглэх нянгийн эсрэг эмүүд ордог бөгөөд тэдгээрийн ойролцоогоор 40% нь ууж хэрэглэх эмүүд байдаг.

Харин хянах буюу **RESERVE** бүлэгт олон эмэнд тэсвэржсэн үүсгэгч бүхий халдварыг эмчлэх эцсийн сонголтын нянгийн эсрэг эмүүд хамаарагдана. Эдгээр эмүүдээс ойролцоогоор 10% орчим нь ууж хэрэглэх эмүүд багтдаг.

Мөн тус ангилалд **зөвлөмж болгохгүй** буюу **NOT RECOMMENDED** гэх нянгийн эсрэг эмийн мэдээллүүд ордог. Энэхүү жагсаалтад хэд хэдэн өргөн хүрээний нянгийн эсрэг эмүүдийг хослуулан хэрэглэхэд эмнэлзүйн үр нөлөө хангалттай үзүүлэхгүй, олон улсын өндөр чанартай эмнэлзүйн удирдамжуудад санал болгодоггүй эмүүдийн мэдээллийг оруулдаг.

ДЭМБ-ын 2019-2023 оны 13-р ажлын төлөвлөгөөнд улс орнуудыг хүртээмжтэй байлгах бүлгийн нянгийн эсрэг эмийн хэрэглээг 60%-д хүргэхийг зөвлөмж болгосон байдаг.

AWaRe ангилал бүхий хэвлэлийг ДЭМБ-аас 2022 онд гаргасан бөгөөд 2023 оны 7 дугаар сард мэдээллийг шинэчлэн 257 нэрийн нянгийн эсрэг эмийг хамруулсан. Үүнээс хүртээмжтэй байлгах бүлэгт 87 нэрийн эм, хянах бүлэгт 141 нэрийн эм харин нөөцлөх бүлэгт

29 нэрийн нянгийн эсрэг эмүүд орсон. Энэхүү ангилалд хэсэг газрын халдварт хэрэглэх нянгийн эсрэг эмүүд хамаарагдаагүй.

Манай улсын эмийн бүртгэлд 2024 оны байдлаар 52 нэрийн нянгийн эсрэг эм байна. Эдгээрийг ДЭМБ-ын 2023 оны AWaRe ангиллын мэдээлэлтэй харьцуулахад хүртээмжтэй байлгах бүлэгт 20, хяналттай байлгах бүлэгт 29 нэрийн эм, харин нөөцлөх бүлэгт 3 нэр төрлийн нянгийн эсрэг эм байна. Бүртгэлийн хугацаа дууссан 18 нэрийн эмийн мэдээллийг энэхүү ангиллын жагсаалтад оруулаагүй.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙЛГАХ НЯНГИЙН ЭСРЭГ ЭМ

№	Олон улсын нэршил	Эм судлалын ангилал	АТС код	Бүлэг
1	Amoxicillin	Penicillins	J01CA04	Хүртээмжтэй байх бүлэг
2	Amoxicillin/clavulanic-acid	Beta-lactam/beta-lactamase-inhibitor	J01CR02	Хүртээмжтэй байх бүлэг
3	Ampicillin	Penicillins	J01CA01	Хүртээмжтэй байх бүлэг
4	Ampicillin/sulbactam	Beta-lactam/beta-lactamase-inhibitor	J01CR01	Хүртээмжтэй байх бүлэг
5	Benzathine-benzylpenicillin	Penicillins	J01CE08	Хүртээмжтэй байх бүлэг
6	Benzylpenicillin	Penicillins	J01CE01	Хүртээмжтэй байх бүлэг
7	Cefadroxil	First-generation-cephalosporins	J01DB05	Хүртээмжтэй байх бүлэг
8	Cefalexin	First-generation-cephalosporins	J01DB01	Хүртээмжтэй байх бүлэг
9	Cefazolin	First-generation-cephalosporins	J01DB04	Хүртээмжтэй байх бүлэг
10	Chloramphenicol	Amphenicols	J01BA01	Хүртээмжтэй байх бүлэг
11	Clindamycin	Lincosamides	J01FF01	Хүртээмжтэй байх бүлэг
12	Doxycycline	Tetracyclines	J01AA02	Хүртээмжтэй байх бүлэг
13	Gentamicin	Aminoglycosides	J01GB03	Хүртээмжтэй байх бүлэг
14	Metronidazole_IV	Imidazoles	J01XD01	Хүртээмжтэй байх бүлэг
15	Metronidazole_oral	Imidazoles	P01AB01	Хүртээмжтэй байх бүлэг
16	Ornidazole_oral	Imidazoles	P01AB03	Хүртээмжтэй байх бүлэг
17	Spectinomycin	Aminocyclitols	J01XX04	Хүртээмжтэй байх бүлэг
18	Sulfamoxole/trimethoprim	Sulfonamide-trimethoprim-combinations	J01EE04	Хүртээмжтэй байх бүлэг
19	Tinidazole_IV	Imidazoles	J01XD02	Хүртээмжтэй байх бүлэг
20	Tinidazole_oral	Imidazoles	P01AB02	Хүртээмжтэй байх бүлэг

Тайлбар: Монгол улсад бүртгэлтэй хүртээмжтэй байх бүлгийн нянгийн эсрэг эмүүд.

ХЯНАЛТТАЙ БАЙХ БҮЛЭГ

№	Олон улсын нэршил	Эм судлалын ангилал	АТС код	Бүлэг
1	Azithromycin	Macrolides	J01FA10	Хяналттай байх бүлэг
2	Cefaclor	Second-generation-cephalosporins	J01DC04	Хяналттай байх бүлэг
3	Cefdinir	Third-generation-cephalosporins	J01DD15	Хяналттай байх бүлэг
4	Cefepime	Fourth-generation-cephalosporins	J01DE01	Хяналттай байх бүлэг
5	Cefixime	Third-generation-cephalosporins	J01DD08	Хяналттай байх бүлэг
6	Cefotaxime	Third-generation-cephalosporins	J01DD01	Хяналттай байх бүлэг
7	Cefpirome	Fourth-generation-cephalosporins	J01DE02	Хяналттай байх бүлэг
8	Ceftazidime	Third-generation-cephalosporins	J01DD02	Хяналттай байх бүлэг
9	Ceftriaxone	Third-generation-cephalosporins	J01DD04	Хяналттай байх бүлэг
10	Cefuroxime	Second-generation-cephalosporins	J01DC02	Хяналттай байх бүлэг
11	Ciprofloxacin	Fluoroquinolones	J01MA02	Хяналттай байх бүлэг
12	Clarithromycin	Macrolides	J01FA09	Хяналттай байх бүлэг
13	Doripenem	Carbapenems	J01DH04	Хяналттай байх бүлэг
14	Erythromycin	Macrolides	J01FA01	Хяналттай байх бүлэг
15	Fosfomycin_oral	Phosphonics	J01XX01	Хяналттай байх бүлэг
16	Imipenem/cilastatin	Carbapenems	J01DH51	Хяналттай байх бүлэг
17	Kanamycin_IV	Aminoglycosides	J01GB04	Хяналттай байх бүлэг
18	Levofloxacin	Fluoroquinolones	J01MA12	Хяналттай байх бүлэг
19	Meropenem	Carbapenems	J01DH02	Хяналттай байх бүлэг
20	Midecamycin	Macrolides	J01FA03	Хяналттай байх бүлэг
21	Moxifloxacin	Fluoroquinolones	J01MA14	Хяналттай байх бүлэг
22	Norfloxacin	Fluoroquinolones	J01MA06	Хяналттай байх бүлэг
23	Ofloxacin	Fluoroquinolones	J01MA01	Хяналттай байх бүлэг
24	Piperacillin/tazobactam	Beta-lactam/beta-lactamase-inhibitor_anti-pseudomonal	J01CR05	Хяналттай байх бүлэг
25	Rifampicin	Rifamycins	J04AB02	Хяналттай байх бүлэг
26	Roxithromycin	Macrolides	J01FA06	Хяналттай байх бүлэг
27	Teicoplanin	Glycopeptides	J01XA02	Хяналттай байх бүлэг
28	Vancomycin_IV	Glycopeptides	J01XA01	Хяналттай байх бүлэг
29	Vancomycin_oral	Glycopeptides	A07AA09	Хяналттай байх бүлэг

Тайлбар: Монгол улсын хяналттай байх бүлгийн эмүүд.

НӨӨЦЛӨХ БҮЛГИЙН НЯНГИЙН ЭСРЭГ ЭМ

№	Олон улсын нэршил	Эм судлалын ангилал	АТС код	Бүлэг
1	Colistin_IV	Polymyxins	J01XB01	Нөөцлөх бүлэг
2	Colistin_oral	Polymyxins	A07AA10	Нөөцлөх бүлэг
3	Linezolid	Oxazolidinones	J01XX08	Нөөцлөх бүлэг

Тайлбар: Монгол улсын нөөцлөх бүлгийн нянгийн эсрэг эмүүд.

ЗӨВЛӨМЖ БОЛГОХГҮЙ НЯНГИЙН ЭСРЭГ ЭМҮҮД

2023 оны AWARe ангилал дахь мэдээлэлд зөвлөмж болгохгүй нянгийн эсрэг эмийн жагсаалтад 103 эмийн мэдээлэл орсон байна. Манай улсад бүртгэлтэй эмүүдээс 30 эмийн мэдээлэл ДЭМБ-ын энэхүү жагсаалттай тохирч байна. Иймд эдгээр 30 хослолоор нянгийн эсрэг эмүүдийг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд практикт хэрэглэхдээ дахин нягтлах шаардлагатай юм.

№	Нянгийн эсрэг эмүүд
5	amoxicillin/clavulanic acid/lactic ferments
6	amoxicillin/clavulanic acid/lactobacillus acidophilus
8	amoxicillin/cloxacillin
9	amoxicillin/cloxacillin/lactic acid
11	amoxicillin/cloxacillin/lactobacillus lactis
17	amoxicillin/metronidazole
21	ampicillin/cloxacillin
22	ampicillin/cloxacillin/lactobacillus acidophilus
23	ampicillin/cloxacillin/saccharomyces boulardii
31	azithromycin/cefixime
34	azithromycin/fluconazole/secnidazole
35	azithromycin/levofloxacin
36	azithromycin/ofloxacin

39	bromhexine/sulfamethoxazole/trimethoprim
50	cefixime/cloxacillin
54	cefixime/levofloxacin
55	cefixime/linezolid
56	cefixime/moxifloxacin
57	cefixime/ofloxacin
58	cefixime/ornidazole
82	ciprofloxacin/metronidazole
83	ciprofloxacin/ornidazole
84	ciprofloxacin/tinidazole
85	doxycycline/tinidazole
86	erythromycin/sulfamethoxazole/trimethoprim
90	kanamycin/penicillin g
91	levofloxacin/metronidazole
92	levofloxacin/ornidazole
95	metronidazole/norfloxacin
99	ofloxacin/ornidazole

Эх сурвалж:

1. Лайсмед цахим платформ
2. WHO AWaRe classification of antibiotics for evaluation and monitoring of use, 2023

ТАНИН МЭДЭХҮЙ

ASTROPHARMACY

Л.Дулмаа. ЭЗУ-ны доктор /Ph.D/ ЭЭХХЗГ-ын
/Эмийн чанар, аюулгүй байдлын тандалт судалгааны
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн/

Сансар огторгуй бол хүний эрүүл мэндэд аюул учруулах хатуу ширүүн орчин бөгөөд сансарт ажиллаж буй хүмүүс Дэлхий дээр үзүүлдэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс алслагдмал байдаг.¹ Гэтэл өвчин бол амьд бодгалийн салшгүй хэсэг тул сансарт үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх нь тухайн үүргийг амжилттай гүйцэтгэхэд чухлаар тавигддаг асуудал юм.^{2, 3} Ялангуяа сансрын орчинд ажиллаж буй хүмүүст бичил таталцал буюу жингүйдлийн нөхцөл байдлаас шалтгаалж жингүйдлийн өвчин, сэтгэцийн өвчин, булчин сулрах, хараа муудах, ясны эмгэг, толгойд шингэн хуримтлагдах, дархлалын тогтолцоо сулрах, цацраг туяаны хор нөлөөнд өртөх болон яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай нөхцөл байдлууд үүсэх боломжтой.⁴

Эмийн бэлдмэл нь өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүн юм.⁵ Гэвч сансарт эмийн үйлдэл нь Дэлхий дээрхээс өөрчлөгдөх боломжтой байдаг байна. Энэ нь сансрын орчинд хүний биеийн физиологи цацраг туяаны нөлөөлөл, дулаан шилжилт, гидростатик даралт, жингүйдэл зэргээс шалтгаалан өөрчлөгдсөнөөр эмийн биохүрэхүй болон шимэгдэлт, тархалт, хувиралт, ялгаралт зэрэг фармакокинетикийн болон фармакодинамикийн үзүүлэлтүүд өөрчлөгддөгтэй холбоотой. Гэвч сансрын орчин дахь эмийн фармакокинетик, фармакодинамикийн талаарх судалгаа хангалттай хийгдээгүй байна.⁴

Эмийн тогтвортой чанарыг үнэлэх удирдамжийг Олон улсын зохицуулалтын зөвлөл (ICH)-өөс гаргасан. Тогтвортой чанарын судалгаа нь эмийн хүчинтэй хугацаа, хадгалах нөхцөл болон эмийг дахин шинжлэх хугацааг тогтоодог.⁶ Сансарт эмийн хадгалах нөхцөл нь өөрчлөгддөг тул тогтвортой чанар нь өөрчлөгдөх боломжтой бөгөөд ялангуяа цацрагийн их хэмжээний нөлөөлөл нь эмийн тогтвортой чанарыг бууруулах хүчин зүйл болдог. Судлаачид сансар огторгуйн өвөрмөц орчин, тухайлбал цацраг туяа, хэт давтамж, бичил таталцал буюу жингүйдэл, нүүрстөрөгчийн давхар ислээр баялаг орчин, чийгшил болон температурын өөрчлөлт зэрэг нь эмийн эмчилгээний идэвхид нөлөөлсөн эсэхийг судалжээ. Сансарт эмийн эмчилгээний идэвх хурдан буурдгийг уг судалгааны дүн харуулсан байна.⁴

Astropharmacy гэдэг нь сансрын аяллын явцад цаг хугацаа эсвэл цацрагийн нөлөөгөөр үүсэх эмийн бүтээгдэхүүний задралтай холбоотой асуудлыг шийдвэрлэснээр сансрын хөлгийн багийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай аюулгүй, эмчилгээний идэвхтэй эмийн бэлдмэлийн нөөцийг багасгах зэрэг ойлголтуудыг багтаасан нэр томъёо юм.²

Astropharmacist буюу сансрын орчинд гүйцэтгэх ажиллагаанд оролцох эм зүйч нь сансрын орчинд тогтвортой, хэрэглэхэд хялбар, аяллын туршид эмчилгээний идэвхээ хадгалах эмийн бэлдмэлийг гаргаж авах чиглэлээр мэргэшсэн байх шаардлагатай юм. Таталцлын хүч үгүй орчинд тарилгын уусмал, тарилгын шингэн, утлага зэрэг эмийн хэлбэрүүдийг хэрэглэхэд хүндрэлтэй байдаг.⁷ Цаашилбал, тэдгээр эм зүйч нь астро-телефармаци, сансрын эм судлал ба фармаковижиланс, судалгаа шинжилгээ, эмнэлзүйн фармакогеномикс зэрэг холбогдох чиглэлүүдээр мэргэших, үүрэг гүйцэтгэх боломжтой⁷ бөгөөд эм зүйч бэлтгэдэг сургалтын байгууллагууд эм зүйчдийг тэдгээр чиглэлээр сургаж мэргэшүүлэх, astropharmacist буюу сансрын эм зүйч бэлтгэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсэн бий болж байна.

Эх сурвалж

1. Buckland, D., Diaz, T., Ives, E., & Lazare, D. (2023). *Expiration Analysis of the International Space Station Formulary for Exploration Mission Planning*.
2. <https://www.nasa.gov/general/an-astropharmacy/> 2024.05.24
3. <https://www.nasa.gov/general/a-flexible-personalized-on-demand-astropharmacy/> 2024.05.24
4. Aziz, S., Raza, M. A., Noreen, M., Iqbal, M. Z., & Raza, S. M. (2022). *Astropharmacy: Roles of Pharmacist in Space*. *INNOVATIONS in pharmacy*, 13(3).
5. <https://www.emro.who.int/health-topics/pharmaceutical-products/index.html> 2024.05.24
6. *Stability Testing of New Drug Substances and Products Q1A(R2)* <https://database.ich.org/sites/default/files/Q1A%28R2%29%20Guideline.pdf>
7. Raza, M. A. (2023). *Training and Education Requirements for Pharmacists in Zero Gravity Environments*. *Innovations in Pharmacy*, 14(2).

ЭМ ХООЛНЫ ХАРИЛЦАН НӨЛӨӨЛӨЛ

*/Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн клиник эм судлаач,
Шинжлэн магадлах ухааны магистр, ахлах дэслэгч Ц. Мишээл/*

Та яагаад эм уух шаардлагатай болсон бэ? Эм уухдаа ямар хоол хэрэглэж болох вэ? Эсвэл бүүр ямар төрлийн шингэнээр даруулан хэрэглэх вэ? Гэсэн асуултад хариулж эсвэл энэ талаар урьд өмнө нь мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч байсан уу?

Дэлхийн зах зээл дээр өсөн нэмэгдэж буй эмийн нэр төрөл, тоо хэмжээ олшрох тусам эмийн оновчтой мэдээллийн хомсдол, эмийн сонголтын алдаа, эмийн хэрэглээний гажуудал ихэсч улмаар энэ нь эмэн эмчилгээний чанар, үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Иймээс эмийн зохистой хэрэглээний асуудал нь бидний өмнө тулгамдаж буй асуудлын нэг болж байна.

Сүүлийн жилүүдэд эмийн зохистой хэрэглээний хүрээнд эм хоорондын харилцан нөлөөллөөс гадна эм хоолны харилцан нөлөөллийг нийлээд судлаж хэрэглэж буй эмтэйгээ уялдуулан зөв хооллохыг зөвлөж байна.

Эм хэрэглэх олон арга байдаг. Үүний дотроос эмийг хоол боловсруулах замаар буюу ууж хэрэглэх нь түгээмэл. Энэ нь хүний биеийн физиологийн үйл ажиллагаанд тохирсон, хэрэглэхэд зовиургүй, тусгай багаж, ажилбар шаарддаггүй хамгийн тохиромжтой арга юм.

Хоол ундны зүйл нь идсэнээс 4,5 -5,0 цагийн дотор бүрэн боловсорч дуусдаг. Хоол идэхээс 20-30 минутын өмнө хэрэглэсэн эмийн эмчилгээний идэвхи хамгийн өндөр байдаг боловч хоолны өмнө хэрэглэсэн эмүүд нь ходоодны PH 1,2 – 1,8 бүхий хүчтэй хүчиллэг орчинд ордгоос зарим эм, ялангуяа байгалийн полимерт нэгдлүүд амархан задралд ордог. Хоол идсэний дараа ходоодны PH 2,0 – 4,0 болдог. Гэдсэнд PH 8,0 – 8,5 байдаг. Энд зарим эм шүлтийн гидролизд ордог.

Хоол унд нь зарим эмийн шимэгдэлт, ялгарах, хоргүйжих процессд нөлөөлж, эмэн эмчилгээний идэвхийг бууруулах, идэвхжүүлэх, эсвэл бүр гаж нөлөө, харшлын урвал илрэх байдал ажиглагддаг. Иймээс аливаа эмийн бэлдмэлийг хэрэглэх гэж байгаа бол хамт хэрэглэх хоол ундны талаарх зөвлөгөөг эмч, сувилагч, эмийн мэргэжилтэнгээс авах шаардлагатай юм.

Энэ нь нөгөө талаараа эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөнүүдийг эргэлтийн хоол хүнсн дээр ихээхэн яригддаг асуудлуудын нэг болоод байна. Яагаад гэж үү?

- Эргэлтэнд ирдэг хүнсний бүтээгдэхүүнүүд нь өөх тос, нүүрс ус ихтэй.
- Олон төрлийн жимсний шүүс
- Түргэн хоол, хагас боловсруулсан бүтээгдэхүүн
- Олон төрлийн ургамлын гаралтай болон сүүтэй цай. Эдгээр нь эмийн эмчилгээнд сөргөөр нөлөөлж эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнд эмчилгээний үр дүн гарахгүй байх, эсвэл эмчилгээнээс харших, гаж нөлөө илрэх зэрэг сөрөг үр дагавруудыг дагуулдаг. Иймд доорхи эмийн бэлдмэлийг хэрэглэж байх үедээ доор дурдсан хоол, ундны зүйлээс татгалзахыг зөвлөж байна.

Эмийн бэлдмэл	Хоол хүнс	Харилцан нөлөөлөл
Аспирин, нитроксилин	Өөх тос ихтэй хоол, гахай, хонины мах, цөцгийн тос, цөцгий	Эмийн үйлдэл нь сулрана.
Аспирин	Тос ихтэй загас	Цус алдах эрсдэл нэмэгдэнэ.
Бисакодил (өтгөн хатсан үед хэрэглэдэг)	Нүүрс ус ихээр агуулсан хүнсний бүтээгдэхүүн	Цусан дахь эмийн агууламж 50% буурна.
Иодын бэлдмэл	Байцаа (прогватрин агуулдаг)	Эмчилгээний идэвх сулрана.
Кальцийн бэлдмэлүүд, антибиотикүүд (тетрацилин, ампициллин, эритромицин) тайвшруулах нойрсуулах эмүүд, аспирин, ибупрофен, парацетамол	Жүрж, нимбэг, чавга, үхрийн нүд, чавга, улаан лоолийн шүүс г.м исгэлэн жүүс, хийжүүлсэн ундаа	Хүний биеийг хордуулах нөлөө нь ихсэнэ. Эмийн задрал явагдана. Шимэгдэлт удааширна.
Бүрээстэй буюу капсултай эмийн хэлбэр	Шүлтлэг эрдэст ус, ундаа рашаан	Эмийн бүрээс гэмтэнэ. Эмийн бодис задрана, шимэгдэлт удааширна.
А, Д, Е, К амин дэмүүд	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Амин дэмийн шимэгдэлт ихсэх бөгөөд та эдгээр амин дэмүүдийг хэрэглэж байх үедээ сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэхэд тохиромжтой байхнээ.
Ихэнхи антибиотикүүд	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Эмийн шимэгдэлт буурч задрал явагдана. Ингэснээр таны биед эм бүрэн үйлчилгээгээ үзүүлж чадахгүй гэсэн үг юм.
Бисакодил, бьюлак, сенна (сенна цай, эм хэлбэрээр) зэрэг суулгуулах эмүүд	Хатаасан жимс, түүхий ногоо, гахайн хүйтэн мах, хөх тарианы гурилын талх, буурцаг	Суулгалт ихсэнэ.
Кофе, цай, шоколад, мах, загас	Төмрийн бэлдмэл	Эмчилгээний идэвх буурна.

Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэлтэй эмийн жагсаалтыг <https://www.emiinjor.mn> линкээр нэвтэрч харах боломжтой.

#VIGIMOBILE АППЛИКЭЙШН

Эмийн гаж нөлөө мэдээлэх илүү хялбар боллоо.

Монгол Улсад гаж нөлөө мэдээлэх үйл ажиллагаа 2020 оныг хүртэл цаасан хэлбэрээр явагдаж ирсэн ба энэ нь тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, илгээхэд хүндрэлтэй төдийгүй, цаг хугацаа ихээр шаарддаг, хүлээн авсан мэдээлэл гаргацгүй, ойлгомжгүй, үнэлгээ хийхэд хүндрэлтэй, хуудас гээгдэх, хаягдах эрсдэлтэй зэрэг олон сул талтай байсан.

Харин манай улс 2021 онд ДЭМБ-ын олон улсын эмийн хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч УППСАЛА төвийн жинхэнэ гишүүн орноор нэгдсэнээр гаж нөлөө бүртгэн, мэдээлэх үйл ажиллагаанд цахим системийг ашиглах бүрэн боломж нээгдэж эхэлсэн.


Вэб-д суурилсан цахим систем хэрэглээнд нэвтэрснээр сүүлийн 6 жилийн байдлаар 1 жилд дунджаар 88 тохиолдол мэдээлэгддэг байсан бол 2023 онд дангаар 232 болж 2,6 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Харин 2024 онд тус систем шинэчлэгдэн илүү хялбар болж, гар утас, компьютерт суурилуулсан ашиглах боломжтой **VigiMobile** аппликэйшн хэрэглээнд нэвтэрлээ.

Тус аппликэйшн нь интернет сүлжээгүй үед гаж нөлөөний мэдээллийг бүртгэх боломжтой бөгөөд, сүлжээнд холбогдсон үед хадгалсан мэдээллийг илгээх боломжийг олгож буйгаараа давуу талтай.

Мөн илгээсэн тохиолдол бүрийг өөрийн төхөөрөмж дээрээ татаж аван, архив үүсгэн, мэдээний сангаа хөтлөх боломжтой юм.

Ингэснээр Манай улсын алслагдсан, хөдөө орон нутгийн аль ч бүсээс эмийн гаж нөлөөний тохиолдлыг хүлээн авах боломж бүрдэж байгаа нь эмийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоонд гарч буй томоохон алхам болж байна.




Дараах зааврын дагуу өөрийн төхөөрөмжид суурилуулан хэрэглэнэ үү.

Эмийн гаж нөлөө мэдээлэх-VigiMobile аппликэйшн Android утсанд суулгах заавар



Эмийн гаж нөлөө мэдээлэх-VigiMobile аппликэйшн iPhone утсанд суулгах заавар



Эмийн гаж нөлөө мэдээлэх-VigiMobile аппликэйшн компьютерт суулгах заавар



Эмнэлгийн мэргэжилтэн Фармаковижилянсын тогтолцоонд оролцох эрх зүйн зохицуулалт:

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 21.3-т зааснаар “ Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн, эмийн эмчилгээний хороо, хангамжийн байгууллага, гадаад улсын эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн төлөөлөгчийн газар нь эмийн гаж нөлөө

мэдээлэгдсэн тохиолдол бүрд энэ тухай эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээлэх үүрэгтэй гэж заасан.

Эмнэлгийн мэргэжилтэн та гаж нөлөө, аюулгүй байдлын тохиолдол бүрийг мэдээлж, эмийн аюулгүй байдлыг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж, фармаковижилансын ёс зүйг эрхэмлэн ажиллах шаардлагатай.

**ЭМ,
ЭМНЭЛГИЙН
ХЭРЭГСЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬ**

29 дүгээр зүйл

29.1.Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд эмнэлгийн мэргэжилтэн, иргэн, холбогдох байгууллага оролцоно.

29.2.Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар эмч дараах эрх, үүрэгтэй:

29.2.1.үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хэрэгцээнд нийцүүлэн оновчтой сонголт хийх, эмчилгээний үр дүнд эргэн хяналт тавих;

29.2.2.эмийн тун, хэмжээ, хэрэглэх арга, эмчилгээний үргэлжлэх хугацаа, илэрч болзошгүй гаж нөлөө, харилцан үйлчлэлийн талаар үйлчлүүлэгчид тайлбарлах;

29.2.3.эмийн гаж нөлөөг хянах, тухай бүр мэдээлэх;

29.2.4.эмийг эмийн жорын стандартын дагуу бичих



**ЭМ,
ЭМНЭЛГИЙН
ХЭРЭГСЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬ**

29 дүгээр зүйл

29.3.Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эм зүйч эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар дараах эрх, үүрэгтэй:

29.3.1.эмнэлгийн мэргэжилтэнд эмийн үйлдэл, хэрэглээний талаар мэдээлэл өгөх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

29.3.2.эмийн сонголт, тун, хэрэглэх хугацаа, бичил биетний эсрэг эмийн хэрэглээ, эм хоорондын болон эм, хүнсний харилцан үйлчлэл, эмийн гаж нөлөөг хянах;

29.3.3.эмийн гаж нөлөө илэрсэн тохиолдолд батлагдсан маягтын дагуу бүртгэн мэдээлэх;

29.3.4.эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэж байгаа эм, биоэбэлдмэлийн чанар, аюулгүй байдалд тандалт судалгаа хийх.



ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

29 дүгээр зүйл

29.4.Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар жор баригч дараах эрх, үүрэгтэй:




29.4.1.эм олгохдоо тухайн эмийн хэрэглэх арга, хадгалах нөхцөл, эмийн зохистой хэрэглээний талаар үйлчлүүлэгчид мэдээлэл өгөх;
29.4.2.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг тусгай жороор, бусад эмийг энгийн жороор олгох



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

29.4.3.жороор олгох эмийг цаасан, эсхүл цахим жорын кодоор олгох; 29.4.4.эмийг иргэнд дахин савлан олгохдоо савлалт, шошго дээр эмийн нэр, тун, хэрэглэх арга, хэмжээг бичсэн байх; 29.4.5.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид бага насны хүүхдийн эмийг олгохдоо эмийн зохистой хэрэглээний талаарх мэдээлэл өгөх.



ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

29 дүгээр зүйл

29.5.Иргэн эмийг зохистой хэрэглэх талаар дараах эрх, үүрэгтэй



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

29.5.1.эмийн талаар үнэн зөв, бодит мэдээллийг эмнэлгийн мэргэжилтнээс авах;
29.5.2.эмийн жорд бичигдсэн эмийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг эмийн сангаас авах;
29.5.3.эмийг эмчийн зааврын дагуу тасалдалгүй, бүрэн, зөв хэрэглэх;
29.5.4.хуурамч байж болзошгүй эмээр үйлчилж байгаа байгууллага, иргэний талаар холбогдох байгууллагад мэдээлэх;
29.5.5.эмийн гаж нөлөөний талаар эрүүл мэндийн байгууллагад мэдээлэх;
29.5.6.эмийн үнийг ил тод байршуулахыг шаардах

29.6.Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар эрүүл мэндийн байгууллага дараах үүрэгтэй:

29.6.1.эмийн хадгалалт, түгээлтийн зохистой дадлын стандартыг хангах;
29.6.2. эмийн зохистой хэрэглээний талаар үйлчлүүлэгчид мэдээлэл, сургалт тогтмол хийх





ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭГДСЭН ЖОРГУЙ ОЛГОХ ЭМИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

№	Худалдааны нэр	Тун хэмжээ, Эмийн хэлбэр
1	Абана	шамхал
2	Аварин	300мг+60мг зөөлөн капсул
3	Агар-15	1г талх эм
4	Агар-15	1г талх эм
5	Агар-15	1кг талх эм
6	Агар-15	0.7г туулагдсан нунтаг
7	Агар-17	0.7г туулагдсан нунтаг
8	Агар-35	1г талх эм
9	Агар-35	0.6г туулагдсан нунтаг
10	Агар-8	0.7г туулагдсан нунтаг
11	Агар-8 /Рай/	1г туулагдсан нунтаг
12	Агар-8 /Хий/	0.7г туулагдсан нунтаг
13	Агар-8 /Хийн/	1г туулагдсан нунтаг
14	Агар-8 /Шүү/	1г талх эм
15	Агар-8 /Эмэгтэйн/	0.7г туулагдсан нунтаг
16	Алгит-4	1г туулагдсан нунтаг
17	Алжисепт	0.6мг+1.2мг хүлхдэг шамхал
18	Алжисепт зогийн бал нимбэгийн амтат	0.6мг+1.2мг хүлхдэг шамхал
19	Асепт	100000 ОУН+0.1г капсул
20	Азулен	6мг/1.5г ам зайлах уусмал
21	Айрч	15мг нундуй дусал
22	Аквадетрим витамин Д3	150000мг/мл-10мл уусмал
23	Акридерм	0.05%-30г тосон түрхэл
24	Акридерм ГК	10мг/г+1мг/г+0.64мг/г-15г крем
25	Акридерм СК	0.64мг/г-30г тосон түрхэл
26	Аксел ибупрофен	100мг/5мл-60мл сироп
27	Аксел парацетамол	250мг-60мл хөмөөл
28	Аксел эвлин	200мг+200мг+20мг шамхал
29	Актисилвер Морнинг	350мг зөөлөн капсул
30	Алсбурон шамхал	1г бүрхүүлтэй шамхал
31	Алгезолол-Ди Эф	0.03%-10мл хамрын цашлага
32	Алгезолол-Ди Эф	0.06%-10мл нүд/хамрын дусалга
33	Алгезолол-Ди Эф	0.03%-10мл нүд/хамрын дусалга
34	Алгезолол-Ди Эф	0.06%-10мл хамрын цашлага
35	Алжикал хөмөөл	5г+2.13г+3.25г-10мл хөмөөл
36	Алка-Зельцер	324мг+965мг+1625мг уусгаж шамхал
37	Аллоком	500мг шамхал
38	Аллохол	бүрхүүлтэй шамхал
39	Алмасан	10г ууж хэрэглэх хөмөөл
40	Алтан гагуурын шингэн ханд	30мл ханд
41	Алтан зэс-8	1г талх эм
42	Алтан зэс-8	1г туулагдсан нунтаг
43	Алтангагуурын ханд	10г-20мл ханд
44	Алфатин	50мг капсул
45	Алфатин	150мл сироп
46	Алифакальцидол капсул 1мкг "TOWA"	1мкг капсул
47	Амбродит	15мг/5мл-100мл сироп
48	Амбродитин	15мг/5мл-100мл сироп
49	Амизон	125мг бүрхүүлтэй шамхал
50	Амизон	250мг бүрхүүлтэй шамхал
51	Анаксониум	6г үрэл
52	Анальгин	500мг шамхал
53	Анар-4	1г туулагдсан нунтаг
54	Анаферон	0.003г дисперсийн шамхал
55	Анаферон /хүүхэд/	0.003г дисперсийн шамхал
56	Анаферон хүүхэд	25мг ууж хэрэглэх дусал
57	Антиноаг	100мг+400мг+60мг+100мг+60мг-20мл Шүршэл
58	Ангримакс	150мг+1.5мг+180мг+25мг капсул
59	Анзисел /гааны амттай/	5мг+4мг+3мг хүлхдэг шамхал
60	Анзисел /зогийн бал лемоны амттай/	5мг+4мг+3мг хүлхдэг шамхал
61	Анзисел цагаан гааны амттай хүлхдэг шамхал	5мг+4мг+3мг хүлхдэг шамхал
62	Анзисел чихэр өвсний амттай хүлхдэг шамхал	5мг+4мг+3мг хүлхдэг шамхал
63	Анзисел чихэр өвсний амттай хүлхдэг шамхал	5мг+4мг+3мг хүлхдэг шамхал
64	Анзисел хуушигтэгийн амттай хүлхдэг шамхал	5мг+4мг+3мг хүлхдэг шамхал
65	Антиривин	382мг нунтаг
66	Антидиари 200	4.1г нунтаг
67	Анти-Прокс капсул	капсул
68	Антисепт Е	250мг; 500мг; 1000мг; 5000мг гель
69	Антисепт Е 80	50мг; 100мг Цашлага
70	Антисепт Х	100мг; 500мг; 1г; 5г гадуур хэрэглэх уусмал
71	Антисепт Х	50мг гадуур хэрэглэх цашлага
72	Антисепт-Х	0.2%-200мг; 300мг; 500мг ам зайлах уусмал
73	Антифламин С Лосон	200мг/1г + 60мг/1г лосон
74	Антифлу кидс	160мг+50мг+1мг нунтаг
75	Антифлу нунтаг	650мг+4мг+10мг нунтаг
76	Антифлу шамхал	325мг+2мг+5мг шамхал
77	Антишенин 05г	0.5г шамхал
78	Ану тайла /хамрын дусалга/	10мл хамрын дусалга
79	Анузол	0.05г+0.02г+0.1г лаа
80	Анстеринин плюс-А	15г мөхлөг
81	Анстай витарипп	20г мөхлөг
82	Ар-Ур 10	1г талх эм
83	Арбивир Здровье	100мг капсул
84	Арбивир Здровье Форте	200мг капсул
85	Арибидол	100мг капсул
86	Арибидол Гидрохлорид	100мг капсул
87	Аржуан	1г талх эм

№	Худалдааны нэр	Тун хэмжээ, Эмийн хэлбэр
88	Арисефо	100мг бүрхүүлтэй шамхал
89	Арисефо	50мг бүрхүүлтэй шамхал
90	Арур-10	0.7г туулагдсан нунтаг
91	Арфен	500мг лаа
92	Арфен	250мг лаа
93	Арфен	125мг лаа
94	Асаргал	0.3г үрэл
95	Асборбины хүчил	50мг шамхал
96	Асборбины хүчил	50мг шамхал
97	Асборбины хүчил	2%-200мг уусмал
98	Асборбины хүчил	2%-200мг уусмал
99	Аскорутин	0.3г шамхал
100	Аскорутин	50мг+20мг шамхал
